



КОВИД 19-ЫН ШАЛТГААНТ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ (СУДАЛГААНЫ ТАЙЛАН)



ИИ.МН
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Ковид 19-ын шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй (судалгааны тайлан)

Тайлангийн агуулга: “Ковид-19”-ийн шалтгаант хөл хорионы үе дэх багш, суралцагчдын нөхцөл байдал, цаашид анхаарах зүйлс.

Захиалагч: Монголын Боловсрол, Шинжлэх Ухааны Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо

Гүйцэтгэсэн: Ч.Бат-Уянга («Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд» ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн)

Хянасан: Д.Тунгалаг, Я.Мөнхчимэг («Бүх нийт боловсролын төлөө!» Иргэний нийгмийн үндэсний эвсэл)

АГУУЛГА

| | |
|--|----------|
| Өмнөх үг | 3 |
| НЭГ. Удиртгал | 4 |
| 1.1. Судалгааны үндэслэл, шаардлага | 4 |
| 1.2. Судалгааны зорилго, зорилт | 4 |
| 1.3. Судалгааны арга зүй | 4 |
| 1.4. Судалгаанд оролцогчдын талаарх ерөнхий мэдээлэл | 6 |
| ХОЁР. Судалгааны хураангуй | 7 |
| ГУРАВ. Судалгааны үр дүн | 8 |
| 3.1. хөл хорионы үеийн багшлахуй..... | 8 |
| 3.1.1. Ажиллах нөхцөл, цалин хөлс өөрчлөгдсөн эсэх | 8 |
| 3.1.2. Мэргэжлийн болоод бусад туслалцаа авсан эсэх | 17 |
| 3.1.3. Сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлсөн эсэх | 20 |
| 3.1.4. Зайны сургалтад бэлэн байсан эсэх | 21 |
| 3.2. хөл хорионы үеийн суралцахуй | 25 |
| 3.2.1. Суралцагчтай холбогдсон давтамж | 25 |
| 3.2.2.Тулгамдсан асуудал | 27 |
| 3.2.3. Бие даан суралцах чадвар | 29 |
| 3.2.4. Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг | 29 |
| 3.3. Дараагийн хөл хорионд бэлэн эсэх | 34 |
| 3.4. Бусад улсын туршлага | 36 |

ӨМНӨХ ҮГ

Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19”-ийн нөлөө 1.6 тэрбум суралцагч, 63 сая багш нарт шууд сөргөөр нөлөөлсөн тоон мэдээ байна. Сургууль хаах үеийн сургалтыг цахим, теле, радио хичээлээр нөхөх оролдлого хийсэн ч бодит байдалдаа суралцагч төдийгүй багш нар шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр дутмаг байсан нь олон судалгаагаар илэрсэн юм.¹ Тухайлбал, нийт суралцагчдын 50% орчим нь, багш нарын олонх нь интернэт, түүнд холбогдох төхөөрөмж дутмаг, түүнчлэн бусад сурагчдын адил гэрээр суралцаж буй өөрсдийн хүүхдээ харж хандахын хажуугаар шавь нарынхаа “тасралтгүй суралцах эрх”-ийг хангахын тулд хэн хэнээс илүү ачаалалтай ажиллаж байв.

Эдгээр шалтгаан боловсролын салбарын ирээдүйг ахин төлөвлөх, хямралын шинэ нөхцөлд боловсрол олгох стратегийг ахин харах, “Тогтвортой хөгжлийн зорилго 4 - Боловсрол 2030”-ыг хэрэгжүүлэхийн чухлыг дэлхий нийтэд санууллаа.

Монгол Улсын хувьд 2020.01.27-ны өдрөөс эхлэн 2019-2020 оны хичээлийн жил дуустал сургуулийг бүрэн хааж, цахим болон теле аргаар хичээллэсэн юм. Энэ үед цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн болон тусгай хэрэгцээт боловсрол, элсэлтийн ерөнхий шалгалтанд зориулж нийт 4210 цагийн теле хичээлийг үндэсний хэмжээнд хүргэсэн албан бус мэдээ байна.

Цаашид төстэй нөхцөлд зайны сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарах асуудлыг илрүүлэх зорилгоор энэхүү “Багшлах, суралцахуйд “КОВИД-19”-ийн шалтгаант хөл хорионы үзүүлсэн нөлөө” судалгааг хийсэн юм. Энэ судалгаа нь зөвхөн багш нараас анкет, ярилцлагын аргаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн хүргэж буй бөгөөд зарим баримт бичгийн судалгааны аргаар нотлох шаардлагатай агуулга буйг анхаарна уу. Цаашид энэ чиглэлээр хөндлөнгийн болоод боловсролын байгууллагын өөрийн, өргөн хүрээний судалгаа шаардлагатай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1 UNESCO., “World Teachers’ Day 2020 Teachers: Leading in crisis, reimagining the future”, 2020. (сүүлд үзсэн 2020.10.05)

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

”Ковид-19”-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улс 2020 оны 1 сарын 27-ны өдрөөс эхлэн 2019-2020 оны хичээлийн жил дуустал бүх шатны сургууль, цэцэрлэгийг бүрэн хааж, цахим болон теле аргаар хичээллэв. Энэхүү сургууль бүрэн хаасан буюу хөл хорионы үеийн дэглэм (цаашид “хөл хорионы үед” гэх) багшлах, суралцахууд хэрхэн нөлөөлснийг илрүүлэх, цаашид тулгарч мэдэх ижил төст нөхцөлд юуг анхаарах, ямар арга хэмжээ авбал зохихыг тодруулахад судалгааны хэрэгцээ, шаардлага оршино.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөл хорионы үеэрх зайны сургалт багшлах, суралцах үйлд хэрхэн нөлөөлснийг тодруулахдаа дараах агуулга (зорилт)-ын хүрээнд мэдээлэл цуглууллаа. Үүнд:

1. Багшлахууд хөл хорионы үзүүлсэн нөлөөг тодруулах:
 - Ажиллах нөхцөл, цалин хөлс өөрчлөгдсөн эсэх;
 - Мэргэжил арга зүйн туслалцаа авсан эсэх;
 - Сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлсөн эсэх;
 - Зайны сургалтад бэлэн байсан эсэх.
2. Суралцахууд хөл хорионы үзүүлсэн нөлөөг тодруулах:
 - Багштай холбогдсон давтамж;
 - Тулгамдсан асуудал;
 - Бие даан суралцах чадвар;
 - Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг.
3. Дараагийн хөл хорионд бэлэн эсэхийг тодруулах;
4. Бусад улсад хөл хорионы үед ямар бодлого барьж буйг тодруулах.

Судалгааны үр дүнд 2020 оны 1 сарын 27-ны өдрөөс эхлэн зарласан хөл хорионы үр дүнд багшлах, суралцахууд тулгарсан бэрхшээлийг тодорхойлж, цаашдын ижил төст нөхцөлд юуг анхаарах талаар тодорхой дүр зураг гарах болно.

Анхаарах нь: Судалгаанд зөвхөн багш гэсэн боловсролын салбарын харилцаанд оролцогч нэг талаас мэдээлэл цуглуулсан болно. Тиймээс суралцахууд үзүүлсэн нөлөөг багшийн үнэлэмжээр дүгнэсэн гэдгийг анхаарна уу. Суралцагчдаас эсвэл эцэг эхчүүдээс гэх мэт бусад оролцогч талуудаас ижил төрлийн судалгаа авахад судалгааны үр дүн зөрүүтэй гарахыг үгүйсгэхгүй.

1.3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургууль гэсэн бүх шатны боловсролын байгууллагад ажилладаг багш нарын төлөөллийг хамруулав.

Судалгааны шийдвэрлэх асуудлын хүрээнд тоон (асуулга) болон чанарын (ганцаарчилсан ярилцлага, сошиал медиа дахь багш нарын сэтгэгдэл), баримт бичгийн судалгааны загвар, арга зүйг хавсруулан хэрэглэсэн. Доорх хүснэгтэд зорилтот бүлгүүдээс мэдээлэл цуглуулахад ашигласан судалгааны үндсэн аргуудын ерөнхий зорилгыг дэлгэрүүлэн харууллаа.

Хүснэгт 1. Судалгааны арга

| Арга | Ерөнхий зорилтот бүлэг | Зорилго |
|-------------------------|---|--|
| Ганцаарчилсан ярилцлага | Багш Боловсролын төрийн бус байгууллагын ажилтан | Судалгааны агуулгыг илүү дэлгэрүүлэх, анкетын судалгааны үр дүнтэй харьцуулалт хийх. |
| Анкет | Багш | Хурдан хугацаанд олон талын мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх. |
| Баримт бичгийн судалгаа | Гадны зарим улсуудын туршлага | Ижил төст нөхцөлд бусад улсын хэрэгжүүлсэн туршлагаас суралцах. |

Судалгаанд нийт 695 багш, боловсролын төрийн бус байгууллагын ажилтан 5, нийт 700 хүн оролцов.

Хүснэгт 2. Судалгааны түүвэрлэлт

| | Анкетын судалгаанд оролцогч | Түүврийн хэмжээ | Хувь |
|----|---|-----------------|------------|
| 1. | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш | 52 | 2.5 |
| 2. | Бага боловсролын байгууллагын багш | 116 | 15.4 |
| 3. | Дунд боловсролын байгууллагын багш | 327 | 58 |
| 4. | Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш | 71 | 6.2 |
| 5. | Дээд боловсролын байгууллагын багш | 129 | 17.9 |
| | НИЙТ | 695 | 100 |

1.4. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд (анкетын) оролцогчдын ерөнхий мэдээллийг нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

| ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | | | |
|-----------------|---|------------|------------|
| 1. | Хүйс | Тоо | Хувь |
| | Эрэгтэй | 72 | 10.3 |
| | Эмэгтэй | 623 | 89.7 |
| 2. | Ажилладаг байгууллагын өмчийн хэлбэр | | |
| | Төрийн | 567 | 81.6 |
| | Хувийн | 112 | 16.1 |
| | Холимог | 16 | 2.3 |
| 3. | Ажилладаг байгууллагын байршил /Бүсээр/ | | |
| | Нийслэл | 422 | 60.8 |
| | Сүхбаатар, Хан-Уул | 183 | 26.3 |
| | Чингэлтэй, Баянгол | 55 | 7.9 |
| | Баянзүрх, Сонгинохайрхан | 133 | 19.2 |
| | Багануур, Багахангай, Налайх | 51 | 7.4 |
| | Орон нутаг | 273 | 39.2 |
| | Төвийн бүс: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв | 82 | 11.8 |
| | Баруун бүс: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд | 53 | 7.6 |
| | Зүүн бүс: Дорнод, Сүхбаатар, Хэнтий | 44 | 6.3 |
| | Хангайн бүс: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл | 94 | 13.5 |
| 4. | Ажилладаг байгууллагын түвшин | | |
| | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш | 52 | 2.5 |
| | Бага боловсролын байгууллагын багш | 116 | 15.4 |
| | Дунд боловсролын байгууллагын багш | 327 | 58 |
| | Мэргэжлийн боловсролын байгууллагын багш | 71 | 6.2 |
| | Дээд боловсролын байгууллагын багш | 129 | 17.9 |
| 5. | НИЙТ | 695 | 100 |

Хоёр. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“КОВИД-19” цар тахлын шалтгаант хөл хорионы үе дэх (2020 оны 1 сарын 27-ны өдрөөс эхлэн 2019-2020 оны хичээлийн жил дуустал) зайны сургалтад багш нар бэлэн байгаагүй нь судалгаанаас харагдлаа.

Багш нар зайны сургалтад шаардлагатай тоног төхөөрөмж, гарын авлага, цахим хичээлийн агуулгаар хангагдаагүй шилжсэн ба тэдний ачаалал өмнөхөөс ихэссэн боловч цалин хөлс багасч, аливаа төрлийн дэмжлэг, тусламжаас ангид ганцаарчлан бодит байдалтай нүүр тулжээ. Суралцагчдын хувьд ч мөн адил теле болон цахим хичээл хийх техник хэрэгсэл, ахуйн боломж бололцоо хангалтгүй байжээ.

Судалгааны үр дүнд цаашдаа тулгарч мэдэх зайны сургалтын үеэр:

- Багшийн ачааллыг тэнцвэржүүлэх, зайны сургалтын онцлогт тохирсон хэлбэрээр ачааллыг бууруулах;
- Багшийн цалин хөлсийг ямар ч тохиолдолд бууруулахгүй байх, боломжтой бол нэмэгдүүлэх;
- Зайны сургалтад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, материалаар хангах;
- Зайны сургалт явуулах талаар арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийг анхаарах, зөвлөмж, удирдамж өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;
- Суралцагчдын суралцах нөхцөл, боломжийг дээшлүүлэх, эрх тэгш байдлыг хангахад анхаарах шаардлагатай нь харагдлаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГУРАВ. Судалгааны үр дүн

3.1. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН БАГШЛАХУЙ

Монгол Улс 2020 оны 1 сарын 27-ны өдрөөс эхлэн 2019-2020 оны хичээлийн жил дуустал бүх шатны боловсролын байгууллагыг бүрэн хааж, цахим болон теле аргаар хичээллэсэн юм. Энэхүү хөл хорионы дэглэм багш нарт ямар нөлөө үзүүлснийг дараах агуулгын хүрээнд тандсан юм. Үүнд:

- Ажиллах нөхцөл, цалин хөлс өөрчлөгдсөн эсэх;
- Мэргэжлийн болоод бусад туслалцаа авсан эсэх;
- Сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлсөн эсэх;
- Зайны сургалтад бэлэн байсан эсэх.


3.1.1. Ажиллах нөхцөл, цалин хөлс өөрчлөгдсөн эсэх.

Хөл хорионы үед багш нарын ажилласан нөхцөлийг тодруулахаар ажлын ачаалал, орчин нөхцөл, цалин хөлс, тоног төхөөрөмжийн хүрэлцээ зэрэг агуулгаар асуумж авсан юм.

а. Ажлын ачаалал ихэссэн эсэх

Судалгаанд оролцсон багш нарын (цаашид “оролцогчид” гэх) 77.3% нь ажлын ачаалал өмнөхөөс “ихэссэн”, 8.7% “багассан” гэж хариулжээ.

График 1. Ажлын ачаалал ихэссэн эсэх /нийт/



Оролцогчдын хүйс, сургуулийн байршил, шатлал, өмчлөлийн хэлбэрээр харвал эмэгтэйчүүд, бага боловсролын болоод холимог өмчит сургуулийн багш нарын ачаалал бусад оролцогчдоос илүү ихэсчээ. Үүнд ялангуяа эмэгтэй, эрэгтэй багш нарын “ачаалал ихэссэн”

гэх хариултын зөрүү 20 орчим хувьтай буй нь эмэгтэйчүүдийн гэр бүлд гүйцэтгэж буй үүрэгтэй холбогдохоос гадна оролцогч эмэгтэйчүүдийн ихэнх нь бага, дунд сургуулийн багш нар, тэдний ачаалал ихэссэнтэй холбоотой. Үүнийг задлан харвал бага сургуулийн багш эмэгтэйчүүдийн 88%¹, дунд сургуулийн багш эмэгтэйчүүд 100%, эрэгтэйчүүдийн 56%, МСҮТ-ийн багш эмэгтэйчүүдийн 71%, эрэгтэйчүүдийн 50%, их, дээд сургуулийн багш эмэгтэйчүүдийн 84%, эрэгтэйчүүдийн 66% нь “ачаалал ихэссэн” гэж хариулсан юм.

1 Эрэгтэй бага сургуулийн багш судалгаанд оролцоогүй.

Түүнчлэн холимог өмчит сургуулийн багш нарын “ачаалал ихэссэн” гэх хувь өндөр буй нь өмчийн онцлогоос шалтгаалсан давхар стандартаас шалтгаалсан байж болох талтай. Холимог өмчит сургуулийн багш нар нэгдсэн журмаар орж буй теле хичээлийн агуулгыг баталгаажуулсан хичээлээс гадна сургуулийн өөрийн хөтөлбөрийн дагуух хичээлийг цахимаар зааж байсан талаар судалгааны явцад дурдаж байв.

Хүснэгт 4. Ажлын ачаалал ихэссэн эсэх /задаргаа/

| | | Ихэссэн | Багассан | Хэвээрээ |
|-----------|----------------------|---------|----------|----------|
| Хүйсээр | Эрэгтэй | 60 | 10 | 30 |
| | Эмэгтэй | 79.2 | 8.6 | 12.2 |
| Байршил | Нийслэл | 76.5 | 10.9 | 12:6 |
| | Орон нутаг | 74.9 | 7.9 | 17.2 |
| Шатлалаар | Сургуулийн өмнөх | 41.7 | 41.7 | 16.7 |
| | Бага боловсрол | 88.2 | 5.3 | 6.6 |
| | Дунд боловсрол | 75 | 10.2 | 14.8 |
| | Мэргэжлийн боловсрол | 69.6 | 13.0 | 17.4 |
| | Дээд боловсрол | 79.8 | 2.2 | 18 |
| Өмчлөлөөр | Төрийн | 76.5 | 8.7 | 14.9 |
| | Хувийн | 80.0 | 8.8 | 11.3 |
| | Холимог | 88.9 | 11.1 | - |

Сургуулийг байршлаар задлан харвал нийслэл, орон нутагт төдийлөн ялгаагүй хариулсан, гэхдээ нарийвчлан харвал нийслэлээс Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг, орон нутгаас Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн багш нарын 80%-аас илүү нь “ачаалал ихэссэн” гэжээ. Гэхдээ судалгаанд оролцогч дээд боловсролын байгууллагын багш нарын 70% нь Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт ажилладаг ба тэдгээр багш нарын бараг 90% нь “ачаалал ихэссэн” гэж хариулсантай энэхүү байршлын дүн холбоотой байж болох юм.


Хүснэгт 5. Ажлын ачаалал ихэссэн эсэх /байршил/

| | | Ихэссэн | Багассан | Хэвээрээ | |
|---|------------|--|----------|----------|------|
| 1 | Нийслэл | Баянзүрх, Сонгинохайрхан | 81.1 | 7.4 | 11.6 |
| 2 | | Сүхбаатар, Хан Уул | 83.2 | 7.6 | 9.2 |
| 3 | | Чингэлтэй, Баянгол | 66.7 | 15.4 | 17.9 |
| 4 | | Багануур, Багахангай, Налайх, | 75 | 13.9 | 11.1 |
| 5 | Орон нутаг | Баруун бүс/Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ | 71.1 | 7.9 | 21.1 |
| 6 | | Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/ | 80 | 10 | 10 |
| 7 | | Төвийн бүс /Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/ | 81 | 3.4 | 15.5 |
| 8 | | Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ | 67.6 | 10.3 | 22.1 |

Сургуулийн өмнөх ба бага, дунд боловсролын түвшний багш нарын хувьд танхимаар хичээллээгүйтэй холбоотойгоор багш хичээлд бэлтгэх, төлөвлөх, заах ажил багасан багш нарын ачаалал өмнөхөөс буурсан байх учиртай мэт ч оролцогчдын 90% орчим нь ажлын ачааллаа “ихэссэн” юм уу “хэвээр” гэж хариулсан үндэслэлийг тодруулсан юм.

Багшийн ажлын ачааллын зонхилох шалтгаанд цахим хичээл бэлдэх, даалгавар шалгах, сурагчидтай холбогдох, удирдлагад ажлаа тайлагнах, бусад буюу багшлахыг гэрийн ажилтайгаа хослуулсан учир зэргээр хариулжээ.²

График 3. Ажлын ачаалал ихсэхэд нөлөөлсөн шалтгаан



“Ачаалалд ихсэхэд нөлөөлсөн” гэх хариултаас мөн адил хүйс, сургуулийн байршил, шатлал, өмчлөлийн хэлбэрээр задлан харахад дээрх үзүүлэлтэд онцын ялгаа харагдаагүй юм. Түүнчлэн “цахим хичээл бэлдэх” гэх хариултыг задлан харахад ялгаагүй байв. Урьдчилсан таамгаар ЕБС-ийн хувьд теле хичээл үзэж буйтай холбоотой “цахим хичээл бэлдэх” ачаалал бага байна гэж тооцсон ч сургуулийн шатлалаар залхан харахад ялгаагүй байв. Энэ нь теле хичээлийн бататгалыг ч мөн адил багш нарын олонх шинээр цахимаар өөрийн арга барилаараа бэлдэж хүргэж байсантай холбоотой нь судалгааны ярилцлагаас харагдав.

ШИГТГЭЭ.

...Теле хичээлийн хурдыг сурагчид гүйцэхгүй, мөн багшийн арга барил зөрж буйгаас ойлгохгүй байдал ажиглагдсан тул агуулгыг бататгаж видео, үзүүлэн хэлбэрээр бэлтгэж байна...

Багш нарын ярилцлагаас


“Сурагчидтай холбогдох” гэх хариултыг бага, дунд, МСҮТ-ийн багш нар түлхүү өгсөн ба сургуулийн байршлаас хамаарахгүй байв.

б. Цалин хөлс өөрчлөгдсөн эсэх

“КОВИД-19”-ийн үед багш нарын цалин хөлс өөрчлөгдсөн эсэхийг тандвал оролцогчдын 54% нь “хэвээрээ”, 42% нь “багассан”, 3.9% нь “нэмэгдсэн” гэжээ.

2 Агуулгыг 2.1.2 Мэргэжлийн туслалцаа авсан эсэх хэсгээс давхар харж болно.

График 4. Цалин хэлст өөрчлөлт орсон эсэх



Үүнийг хүйс, байршил, сургуулийн шатлал, өмчлөлийн хэлбэрээр задлан харахад дараах үр дүн гарчээ.

Хүснэгт 6. Цалин хэлст өөрчлөгдсөн эсэх /задаргаа/

| | | Хэвээрээ | Нэмэгдсэн | Багассан | |
|--|------------------|---|-----------|----------|------|
| Хүйсээр Эмэгтэй | Эрэгтэй | 68 | 6 | 26 | |
| | | 52.6 | 3.6 | 43.6 | |
| Шатлалаар Бага боловсрол Дунд боловсрол Мэргэжлийн боловсрол Дээд боловсрол | Сургуулийн өмнөх | 16.7 | 8.3 | 75 | |
| | | 56.6 | 2.6 | 40.8 | |
| | | 46,8 | 2.5 | 50.7 | |
| | | 78.3 | 8,7 | 13 | |
| | Дээд боловсрол | 73 | 7.9 | 19.1 | |
| Өмчлөлөөр Хувийн Холимог | Төрийн | 54.5 | 4.2 | 41.1 | |
| | | 50 | 1.3 | 48.8 | |
| | | 66.7 | 11.1 | 22.2 | |
| Байршил | Нийслэл | Баянзүрх, Сонгинохайрхан | 56.8 | 3.2 | 40 |
| | | Сүхбаатар, Хан Уул | 61.1 | 6.1 | 32.8 |
| | | Чингэлтэй, Баянгол | 46.2 | | 53.8 |
| | | Багануур, Багахангай, Налайх, | 44.4 | - | 55.6 |
| | Орон нутаг | Баруун бүс/Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ | 52.6 | 5.3 | 42.1 |
| | | Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/ | 65 | - | 35 |
| | | Төвийн бүс /Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/ | 34.5 | 5.2 | 60.3 |
| | | Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ | 60.3 | 2.9 | 36.8 |

Оролцогчдын бараг тэн хагас “цалин хөлс багассан”, үүн дундаа нийслэлээс Чингэлтэй, Баянгол, Багануур, Багахангай, Налайх дүүрэг, орон нутгаас Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудын оролцогчид 50 хувиас илүү нь “цалин хөлс багассан” гэж хариулжээ. Гэхдээ үүнээс шууд “цалинг хассан байна” гэх дүгнэлт хийхийн өмнө шалтгаан болоод “цалин” гэдэгт юуг хамруулж ойлгож буйг анхаарах шаардлагатай.

Хүснэгт 7. Цалин хөлс багассан шалтгаан /Давтамжийн эрэмбээр/

| | Шалтгаан |
|---|--|
| 1 | Зөвхөн үндсэн цалингаа авсан тул илүү цагаар ажиллах, анги даах, хоол унааны зэрэг бүх нэмэгдэл урамшуулал хасагдсан |
| 2 | Танхимаар хичээллээгүй тул ачаалал буурсан гэх үндэслэлээр |
| 3 | Лабораторийн хичээлийн цаг хасагдсан гэх үндэслэлээр |
| 4 | Байгууллагын санхүүгийн чадавхи, орлого буурсан гэх үндэслэлээр |
| 5 | Цахим хичээлийн үр дүнгээс шалтгаалан |
| 6 | Ангийн сурагчид сургалтын төлбөр төлөөгүй гэх үндэслэлээр |
| 7 | Хичээлээ цахим болгоогүй, удирдлагын даалгаврыг цаг тухайд биелүүлээгүй гэсэн үндэслэлээр |
| 8 | Хассан шалтгааныг тайлбарлаагүй |

Үүнээс харвал оролцогчдын ихэнх зөвхөн үндсэн цалин олгож буйг “цалин хассан” гэж үзсэн байх магадлалтай. Анхлан хөл хорио зарлах үед ч төрийн байгууллагуудын зүгээс багш нарын зөвхөн үндсэн цалинг олгохыг мэдэгдэж байсан билээ. Энэ нь оролцогчдын “цалин хасах” гэдэгт юуг ойлгож буйгаас гадна сэтгэл ханамжийн байдлыг харуулж байх талтай. Гэхдээ энэ тохиолдолд зөвхөн үндсэн цалинг олгосонг багшийн ачаалалтай холбон ахин нэг харах шаардлагатай.

Ажлын ачаалал, цалин хөлс хоорондоо урвуу хамааралтай байгаа нь нийт оролцогчдын 77.3% нь “ажлын ачаалал ихэссэн” гэх мөртлөө 42% нь “цалин багассан” гэж хариулснаас харагдана. Тухайлбал, “ачаалал ихэссэн” гэж 80%-иас илүү нь хариулсан Төвийн бүсийн аймгууд болох Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн оролцогчдын 65.5% нь “цалин багассан” эсхүл “цалин хасагдсан” гэж хариулжээ.

“Ажлын ачаалал ихэссэн” ба “цалин багассан” гэх хариултын харилцан хамаарлыг харахад “ажлын ачаалал” ихэссэн гэж хариулсан оролцогчдын 80.7% нь “цалин багассан” гэж хариулсан юм.

Мөн цалин хөлсний “хасагдсан” гэх хариултын зөрүү хүйсээр ялгаатай байгааг анхаарч, улсын нэгдсэн дүн мэдээтэй тулгах шаардлагатай. “Цалин багассан” гэх хариултын хүйс хоорондох зөрүү 20% орчим, “нэмэгдсэн” гэх хариултын зөрүү 15% байна. Бага ангийн багш оролцогчдын 88.2% “ажлын ачаалал ихэссэн” гэж хариулсан мөртлөө 40% нь “цалин багассан”, 2.6% нь “цалин нэмэгдсэн” гэж

хариулжээ.

Ангийн сурагчид сургалтын төлбөр төлөөгүй, байгууллагын орлого буурсан гэх үндэслэлийг хувийн сургуулийн багш нар хариулсан юм. Улсын төсвөөс хувьсах зардлаа бүрэн авсан тохиолдолд энэ үндэслэл хэрвээ “үнэн” буюу баримтаар нотлогдвол зүй бус үйлдэл юм.

Цалин бууруулсан үндэслэлийн хоёрдугаарт “танхимаар хичээллээгүй тул ачаалал багассан” гэх үндэслэл буй атал судалгаанд оролцогчдын 77.3% нь “ажлын ачаалал ихэссэн” гэж хариулсанг бодууштай. Гэхдээ мөн адил энэ хариултын шалтгаан нь аливаа нэмэгдэлгүй үндсэн цалин авч буй байдлаа “цалин бууруулсан” гэж үзэж буйд байна.

“Илүү цагаар ажилласан, анги даасан, хоол унааны зэрэг нэмэлт бүх хөлс, урамшуулал хасагдаж үндсэн цалинг олгосон” гэх үндэслэл дунд сургуулийн багш нарын хувьд зонхилж байна.

Засгийн газрын 2019 оны 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын нэг сарын цалин 587,385-аас 964,899 төгрөг хүртэл, мэргэжлийн боловсрол олгох боловсролын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын нэг сарын цалин 625,966-аас 995,822 төгрөг хүртэл буй юм.


Харин Үндэсний статистикийн хорооноос баталсан 2020 оны хүн амын амьжиргааны доод түвшин баруун бүст 203,400, хангайн бүст 206,000, төвийн бүст 198,300, зүүн бүст 201,700, Улаанбаатарт 230,000 төгрөг байжээ.

Үндсэндээ зайн сургалтын үед багшийн аливаа нэмэгдэл цалинг олгоогүй нь зүй зохистой эсэх, энэ нь ачаалалтай хэр уялдаж буйг дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

в. Тоног төхөөрөмж хүрэлцээтэй байсан эсэх

Зайны сургалтын үед багш нар цахимаар дамжуулж, теле хичээлийг бататгах болон тухайн сургуулийн сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл орж байсан гэх ба энэ үед цахим хичээл заахад шаардлагатай зүйлсээр хангагдсан эсэхийг тодруулсан юм. Оролцогчдын 18.5% нь ухаалаг утасгүй, 82.5% нь суурин компьютергүй, 14.4% нь зөөврийн компьютергүй, 20.7% нь гэртээ интернэтгүй байсан хэмээн хариулжээ. Гэхдээ “тоног төхөөрөмжтэй байсан” гэж хариулсан оролцогчид хөл хорионы нийт хугацаанд хамруулж хариулсан ба шинээр худалдаж, түрээслэж авснаа мөн багтаан хариулсан байв.

График 5. Тоног төхөөрөмж байсан оролцогчид



Оролцогчдын хүйс, сургуулийн шатлал, байршил, өмчлөлийн хэлбэрээр задлан харахад дээрх үзүүлэлтэд онцын ялгаа харагдаагүй юм.

Үүнтэй холбогдуулж зайнаас ажиллах үед ажлаа хийхэд зориулж нэмэлт зардал гарсан эсэхийг тодруулахад оролцогчид 100% “нэмэлт зардал гарсан” гэх ба доорх таван зардлыг дурдав.

Хүснэгт 8. Гарсан нэмэлт зардал /Давтамжийн эрэмбээр/


| № | Шалтгаан |
|---|--|
| 1 | Компьютер, чихэвч, камер, микрофон зэрэг тоног төхөөрөмж худалдаж авсан зардал |
| 2 | Гэртээ интернэт шинээр суурилуулах зардал, |
| 3 | Гэрийн интернэтийн хурдны багцаа ахиулсан зардал |
| 4 | Утасны төлбөр |
| 5 | Датаны төлбөр |
| 6 | Цахилгааны төлбөр |

Нэмэлт зардлын дүнг барагцаалбал хамгийн багадаа сар бүр 30.000-40000 төгрөгийг утас, дата, интернэтийн төлбөрт илүү зарцуулах болсон гэсэн бол тоног төхөөрөмж шинээр худалдаж авахад нэг удаад 100.000-аас 2.000.000 төгрөг хүртэл тухайлбал зөөврийн компьютер худалдаж авахад хоёр сая орчим төгрөг, утас худалдаж авахад нэг сая орчим төгрөг, камер, чихэвч зэрэг хэрэгсэл авахад зуун мянга орчим төгрөг нэг удаад зарцуулсан байна. Түүнчлэн шинээр худалдаж авсан зөөврийн компьютер, утсыг “лизингээр худалдаж авсан” гэх хариулт олон байв.

Зарим нэг сургуулийн хувьд л датаны эрх бүхий дугаар шинээр олгосон гэхээс өөр энэ зардлыг үүрэлцэх талаар ямар нэг санаачлага гараагүй хэмээн оролцогчид хариулсан юм.

Оролцогчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор интернэтэд хаанаас нэвтэрч байсныг мөн асуухад 18.4% нь гэр, ажлаас бусад газраас буюу кофешоп, найзын гэр, нөхрийнхөө ажил дээрээс зэрэг хариултууд давамгайлж байв.

График 6. Интернетэд нэвтэрсэн байршил



Энэ хариултыг оролцогчдын хүйс, сургуулийн шатлал, байршил, өмчлөлийн хэлбэрээр задлан харахад дээрх үзүүлэлтэд онцын ялгаа харагдаагүй юм.

г. Гэрээс ажиллах нөхцөл

Хөл хорионы дэглэмийн үе учир ажиллах нөхцлийн онцлог нь оролцогчид гэрээсээ ажиллаж буйд байв. Иймд гэрээсээ ажиллах үед эерэг, сул тал үүссэн эсэхийг дараах асуултаар тодруулсан юм.

Хүснэгт 9. Гэрээс ажиллахын эерэг, сул үр дүн

| | | Тийм | Үгүй | Заримдаа |
|---|---|------|------|----------|
| 1 | Гэрийн ажлаа хослуулан ажиллахад хүндрэлтэй байсан уу? | 52 | 19.8 | 28.2 |
| 2 | Гэр бүлдээ зарцуулах цаг ихтэй болсон уу? | 45.2 | 28.1 | 26.7 |
| 3 | Гэрт ажиллах зай, талбай хүрэлцэхгүй байсан уу? | 41.4 | 20.8 | 37.8 |
| 4 | Суралцагчидтай харилцах хангалттай цаг байсан уу? | 45.6 | 28.6 | 25.8 |
| 5 | Эцэг эхчүүдтэй харилцах илүү боломжтой болсон уу? | 40.5 | 35.3 | 24.2 |
| 6 | Сургуулийн удирдлагатай холбогдох хангалттай цаг байсан уу? | 48.4 | 27 | 24.6 |

Оролцогчдын тэн хагас нь гэрээс ажиллахад хүндрэлтэй байсан, нийт дүнгээр 80% орчим нь гэрээс ажиллахад “байнга” болон “заримдаа хүндрэлтэй байсан” гэж хариулсан юм.

Үүнийг хүйс, бүс, сургуулийн шатлал, өмчлөлийн хэлбэрээр харвал дараах үр дүн гарчээ. Үүнд зөвхөн “тийм, заримдаа” гэх хариултыг онцлоё.

Хүснэгт 10. Гэрээс ажиллахын эерэг, сул үр дүн/Хүйсээр/

| | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---------|----------|---------|----------|
| | тийм | заримдаа | тийм | заримдаа |
| Өрх, гэрийн ажлаа хослуулан ажиллахад хүндрэлтэй байсан уу? | 38 | 30 | 53.5 | 22.6 |
| Гэр бүлдээ зарцуулах цаг ихтэй болсон уу? | 52 | 20 | 44.7 | 17.6 |
| Гэрт ажиллах зай, талбай хүрэлцэхгүй байсан уу? | 36 | 24 | 33.2 | 14 |
| Суралцагчидтай харилцах хангалттай цаг байсан уу? | 20 | 24 | 38.4 | 21.7 |
| Эцэг эхчүүдтэй харилцах илүү боломжтой болсон уу? | 42 | 26 | 46 | 15.8 |
| Сургуулийн удирдлагатай холбогдох хангалттай цаг байсан уу? | 36 | 32 | 42 | 22.1 |

Хүйсээр харвал эрэгтэйчүүдийн 32%, эмэгтэйчүүдийн 76.1% нь “өрх гэрийн ажлаа багшлах ажилтай хослуулах хүндрэлтэй” байсан, эрэгтэйчүүдийн 60,5% нь “гэрт ажиллах зай талбай хүрэлцэхгүй” байсан хэмээн хариулжээ. Энэ нь хүйсээс үүдэлтэй гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарьтай холбоотой байж болох юм.

Хүснэгт 11. Гэрээс ажиллахын эерэг, сул тал /Шатлалаар/

| | Сургуулийн өмнөх | | Бага | | Дунд | | Мэргэжлийн | | Дээд | |
|--|------------------|----------|------|----------|------|----------|------------|----------|------|----------|
| | тийм | заримдаа | тийм | заримдаа | тийм | заримдаа | тийм | заримдаа | тийм | заримдаа |
| Гэрийн ажлаа хослуулан ажиллахад хүндрэлтэй байсан уу? | 66,7 | - | 27.6 | 27.6 | 22,9 | - | 30,4 | | | 24,7 |
| Гэр бүлдээ зарцуулах цаг ихтэй болсон уу? | 50 | - | 44.7 | 15.8 | 47.2 | 19 | 52.2 | 8.7 | 39.3 | 21.3 |
| Гэрт ажиллах зай, талбай хүрэлцэхгүй байсан уу? | 58.3 | 8.3 | 31.6 | 11.8 | 31.7 | 15.8 | 34.8 | 13 | 39.3 | 15.7 |
| Суралцагчидтай харилцах хангалттай цаг байсан уу? | 66.7 | 16.7 | 13.2 | 13.2 | 47.9 | 16.9 | 56.5 | 30.4 | 41.6 | 15.7 |

| | | | | | | | | | | |
|---|-------|------|------|------|------|------|------|------|------|------|
| Эцэг эхчүүдтэй харилцах илүү боломжтой болсон уу? | 58.,3 | 25 | 32.9 | 23.7 | 43.7 | 22.2 | 34.8 | 26.1 | 14.6 | 18 |
| Сургуулийн удирдлагатай холбогдох хангалттай цаг байсан уу? | 33.3 | 16.7 | 42.1 | 21.1 | 46.5 | 24.3 | 39.1 | 13 | 28.1 | 24.7 |

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын 66.7%, бага боловсролын багш нарын 55%, дунд боловсролын багш нарын 22.9%, мэргэжлийн боловсролын багш нарын 30.4%, дээд боловсролын багш нарын 24.7% нь “гэрийн ажлаа багшлах ажилтайгаа хослуулахад хүндрэлтэй байсан” хэмээжээ. Мөн аль ч шатлалын багш нарын 50% нь гэрт “ажиллах зай, талбай хүндрэлтэй байсан” талаар дурджээ.

Харин хөл хорионы үед сургуулийн шатлал, хүйсээс үл хамаарч суралцагч, эцэг эх, сургуулийн удирдлагатай холбогдох боломж “илүү дээрдсэн” хэмээн 50%-иас дээш хариулжээ.

3.1.2 Мэргэжил арга зүйн болон бусад туслалцаа авсан эсэх


Зайн сургалтын үеэр сургуулийн удирдлага, дүүрэг, аймгийн Боловсролын газар болоод Боловсролын яамнаас багш нарт дэмжлэг үзүүлсэн эсэх талаар оролцогчдын 15.2% нь сургуулийн удирдлага, 33.5% нь дүүрэг, аймгийн Боловсролын газар, 23.6% нь Боловсролын яам тус тус “дэмжлэг огт үзүүлээгүй” хэмээн хариулжээ.

Дэмжлэг үзүүлсэн гэх хариултыг харвал оролцогчдын 68.3% нь сургуулийн удирдлагаас, 38.3% нь дүүрэг, аймгийн Боловсролын газраас, 38.7% нь Боловсролын яамнаас “чиглэл, удирдамжаар ханган ажилласан” хэмээн дүгнэжээ.

Анхаарах нэгэн хариулт нь оролцогчдын 7.8% нь сургуулийн удирдлага, 1.8% нь дүүрэг, аймгийн Боловсролын газар, 26% нь Боловсролын яам “төсөв санхүүгээр дэмжсэн” гэж хариулсан буюу энэ төрлийн дэмжлэг доогуур үзүүлэлттэй байжээ. Үүнийг оролцогчдын 40.8% нь “цалин багассан” гэж хариулсантай болоод ажлаа хийхэд зарцуулсан нэмэлт зардалтай уялдуулан харах шаардлагатай.

Мөн гарын авлага, сургалтын материал, арга зүйн сургалт, цахим хичээлийн талаар зааварчилгаа өгсөн гэх үзүүлэлт аль ч шатны удирдах байгууллагаас хангалтгүй байжээ. Үүнийг сургуулийн шатлал, байршил, өмчлөлөөр харахад ч онцын өөрчлөлтгүй. Гэтэл оролцогчдын 90% орчим нь зайн сургалтын үед ажлын ачаалал “ихэссэн” эсвэл өмнөхтэй “хэвээр” гэж хариулсан агаад үүнийхээ шалтгаанаар цахим хичээл бэлдэх, даалгавар шалгах зэргийг дурдаж байсан юм.

График 7. Дэмжлэг үзүүлсэн эсэх



Үүнийг нарийвчлан 2020 оны 2 дугаар сарын 1-нээс хойш хугацаанд Боловсролын яамнаас багш нарт чиглэн ямар ажил зохион байгуулсан талаар лавласан асуултынхариултыг эрэмбээр харуулбал дараах байдалтай байна. Хариултын ерөнхий уур амьсгал сөрөг байгааг үүнээс харж болно.


Хүснэгт 12. Боловсролын яамнаас дэмжлэг үзүүлсэн эсэх

| | Хариулт | Тоо |
|---|--|------------|
| 1 | Зохион байгуулаагүй | 302 |
| 2 | Санахгүй байна | 102 |
| 3 | Мэдэхгүй | 65 |
| 4 | Дарамт мэдрүүлснээс өөр дорвитой ажил хийгээгүй. | 62 |
| 5 | Цахим, теле хичээл | 106 |
| 6 | Тушаал шийдвэр өгсөн | 78 |
| 7 | Журнал хөтлөх заавар | 10 |
| 8 | Дататай дугаар олгосон | 1 |
| 9 | Зөвлөмж | 1 |
| | НИЙТ | 727 |

Энэ нь Боловсролын яамнаас багш нарт ямар нэг дэмжлэг “үзүүлээгүй” гэх нотолгоо шууд болохгүй ба багш нар үзүүлсэн ямар нэг дэмжлэгийг мэдээгүй эсхүл сөргөөр хүлээж авсан зэргээр тэдний хандлагыг л харуулж буй үзүүлэлт юм.


Мөн энэ үеэр ерөнхий боловсролын сургуулийн хувьд Эцэг эхийн зөвлөл, дээд боловсролын сургуулийн хувьд Оюутны Зөвлөл багш нарт дэмжлэг үзүүлэх ямар нэг ажил хийсэн талаар лавлахад оролцогчдын 82% орчим нь “үгүй” хэмээн хариулсан байна.

График 8. Эцэг эхийн зөвлөл, Оюутны зөвлөл дэмжлэг үзүүлсэн эсэх



Зайны сургалтын үеэр өмнө бий болсон ямар нэг цахим сургалтын агуулгыг ашигласан эсэхийг асуухад оролцогчдын 41.3% нь өмнө бэлдсэн цахим зайны сургалтын материал “ашиглаагүй”, үлдэх нь Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Хан академи, Зайны сургалтын үндэсний төвийн бэлтгэсэн, бусад багш нарын бэлтгэсэн болоод өөрөө бэлтгэсэн материал ашиглажээ. Энд оролцогчдын 77.3% нь “ажлын ачаалал ихэссэн” ба үүний зонхилох шалтгаанд цахим хичээл бэлдэхээс үүдэлтэй гэж хариулсныг анхаарч үзэх ёстой. Өмнө дурдсанчлан “цахим хичээл бэлдэх” гэх хариултыг сургуулийн өмчлөл, байршил, шатлалаар задлан харахад ялгаагүй байсныг анхаарах ёстой. Мөн зайны сургалт эхлэх үед багш нарт хангалттай хичээлийн бэлдэц материал байгаагүй эсхүл байсанг багш нар мэдээгүй гэж үзэх үндэслэлтэй.

График 9. Өмнө бий болсон ямар нэг цахим сургалтын агуулга ашигласан эсэх




Оролцогчдоос ямар арга хэрэгсэл ашиглаж зайны сургалтыг зохион байгуулсныг асуувал:

Хүснэгт 13. Зайны сургалт орсон арга хэрэгсэл

| Арга |
|---------------------------------|
| 1. Facebook |
| 2. Zoom |
| 3. Google mail/ meeting/ form |
| 4. Сургуулийн сайт (sisi зэрэг) |

Сурагчидтайгаа төдийгүй сургуулийн удирдлагатай холбогдоход оролцогчид түлхүү Facebook ашиглажээ. Сургуулийн удирдлагаас багш нарын ажлыг ч түлхүү Facebook (51.2%), мэйл (18.1%) ашиглан хянажээ.

График 10. Сургуулийн удирдлага багшийн ажлыг хянасан арга хэрэгсэл




Үндсэндээ цаашид зайны сургалтыг зохион байгуулахдаа багш нар сошиал платформ түлхүү ашиглаж буйг анхаарах ёстой.

3.1.3. Сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлсөн эсэх

Гэнэт хөл хорио зарлаж, зайнаас хичээллэх болсон үед багш нарын сэтгэцийн байдал ямар байсан талаар тандан үзвэл оролцогчдын 14% нь сандрах, түгших, өөртөө итгэлгүй байх, айх, зугатмаар санагдах мэдрэмж “их эсхүл маш их” төрж байжээ. Ерөнхийдөө талаас илүү нь (57.3%) эдгээр сэтгэл зүйн байдал “огт мэдрэгдээгүй” гэж хариулжээ. Энэ үр дүн оролцогчдын хүйс, сургуулийн байршил, өмчлөлөөс үл хамаарч ижил байлаа.

График 11. Зайны сургалт эхлэх үед багш нарын сэтгэцийн байдал



Харин зайны сургалтын явцад оролцогчдын дунд ажлын ачаалал ихэссэнээс болон багаар ажилладаг байдлаа санагалзах, ганцаардах, тусгаарлагдах мэдрэмж төрж байжээ. Энэ үр дүн оролцогчдын хүйс, сургуулийн байршил, өмчлөлөөс үл хамаарч ижил байлаа.

Хүснэгт 14. Зайны сургалтын үед сэтгэл зүйн байдал

| | | Хувь |
|---|--|------|
| 1 | Ажлын ачаалал ихэссэн учир стресстэх | 63.4 |
| 2 | Багаар ажилладаг байдлаа санагалзах | 50.8 |
| 3 | Ганцаардах | 21 |
| 4 | Тусгаарлагдах | 19.1 |
| 5 | Сэтгэлээр унах, гутрах | 10.7 |
| 6 | Өөртөө итгэлгүй болох | 6.5 |
| 7 | Бусад: <ul style="list-style-type: none"> • Сурагчидтайгаа тулж ажиллаж чадахгүй байсан учир бухимдсан • Хөдөө амьдардаг хүүхэдтэйгээ холбогдож чадахгүй байсан тул санаа зовсон • Эмзэг бүлгийн хүүхдүүддээ “үдийн хоолгүй учир өлсөж байх вий” гэж санаа зовсон. • Сурагчид тогтмол хариу барихгүй, даалгавар хийхгүй байсан учир хямарсан | 4.6 |
| 8 | Сэтгэл хямраагүй, зайнаас ажиллах нь таалагдсан | 3.6 |

3.1.4 Зайны сургалтад бэлэн байсан эсэх

Манай улс 2002 онд “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” батлан, энэ хөтөлбөрийн өмнөтгөлд “...Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас төдийлэн шалтгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах тогтолцоо бий болгох нь чухал байна. Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсрол, техник, технологи, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх, хүүхдийн суралцах, хөгжих эрхийг тэгш боломжоор хангах, иргэдийн насан туршдаа суралцаж, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, амьдрах чадвараа хөгжүүлэхэд зайны сургалт чухал ач холбогдолтой гэдгийг иш үндэс болгож, зайны сургалтын нөөц, шинээр бий болж байгаа боломжийг тогтвортой бүтэц болгон өргөжүүлж үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийн тулд Засгийн газраас Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг гаргаж байна.…” хэмээн дурдсан байдаг. Хөтөлбөр батлагдаж, хэрэгжиж эхэлснээс хойш 18 жилийн дараа үүссэн “КОВИД-19”-ийн шалтгаант зайны сургалтад багш нар бэлэн байсан эсэхийг дөрвөн үзүүлэлтээр оролцогчдоос асуусан юм.

График 12. Зайны сургалтад бэлэн байсан эсэх/Хүйсээр/



Оролцогчдын 73.3% нь өмнө нь зайны сургалтаар “хичээл зааж байгаагүй”, 75.2% нь ийм төрлийн “сургалтад хамрагдаж байгаагүй”, 20% нь цахим хэрэгсэл “ашиглаж мэдэхгүй”, 2.8% нь цахим орчны программ хангалттай “ашиглаж мэдэхгүй” байдалтайгаар зайны сургалт эхлүүлжээ.

Үүнийг хүйсээр нарийвлан харвал эрэгтэйчүүдийн 60%, эмэгтэйчүүдийн 76.3% нь өмнө зайнаас хичээл зааж үзэж байгаагүй гэж хариулсан ба ерөнхийдөө эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол 10% орчим илүү “зайны сургалтад бэлэн байгаагүй” хэмээн хариулжээ.

Хүснэгт 15. Зайны сургалтад бэлэн байсан эсэх/Хүйсээр/

| | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---------|------|---------|------|
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Өмнө нь зайнаас хичээл зааж үзсэн байсан | 40 | 60 | 23,7 | 76,3 |
| Өмнө нь зайны сургалт хийх чадвар олгох сургалтад хамрагдсан байсан | 36 | 64 | 21,7 | 78.3 |
| Цахим хэрэгсэлтэй хангалттай ажиллаж чадаж байсан | 86 | 14 | 79,5 | 20.5 |
| Цахим орчны программ ашиглаж мэддэг байсан | 82 | 18 | 76.5 | 23.5 |

Оролцогчдыг сургуулийн шатлалаар задлан харвал дээд сургуулийн багш нар бусдаасаа арай илүү өмнө нь зайнаас хичээл зааж үзсэн, ийм төрлийн сургалтад хамрагдаж байжээ. Энэ нь “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” гол төлөв их, дээд боловсролын багш нарт чиглэсэн болоод угаас дээд боловсролын сургалтын онцлогтой холбоотой байж болох юм. Харин бага, дунд сургуулийн багш нарын 70%-иас илүү нь өмнө зайнаас хичээл заах эсвэл ийм төрлийн сургалтад хамрагдаж байгаагүй ажээ. Үүнийг хамгийн олон суралцагчтай ерөнхий боловсролын сургуулийн онцлогтой холбон бодвол энэхүү хөл хорионы үеийн зайны сургалтын чанарын асуудал эргэлзээтэй.

Хүснэгт 16. Зайны сургалтад бэлэн байсан эсэх/Сургуулийн шатлалаар/

| | Сургуулийн өмнөх | | Бага | | Дунд | | Мэргэжлийн | | Дээд | |
|---|------------------|------|------|------|------|------|------------|------|------|------|
| | тийм | үгүй | тийм | үгүй | тийм | үгүй | тийм | үгүй | тийм | үгүй |
| Өмнө нь зайнаас хичээл зааж үзсэн байсан | 8,3 | 91,7 | 26,3 | 73,7 | 23,2 | 76,8 | 26,1 | 73,9 | 41,6 | 58,4 |
| Өмнө нь зайны сургалт хийх чадвар олгох сургалтад хамрагдсан байсан | 33,3 | 66,7 | 22,4 | 77,6 | 19 | 81 | 21,7 | 78,3 | 37,1 | 62,9 |
| Цахим хэрэгсэлтэй хангалттай ажиллаж чадаж байсан | 66,7 | 33,3 | 77,6 | 22,4 | 78,2 | 21,8 | 87 | 13 | 89,9 | 10,1 |
| Цахим орчны программ ашиглаж мэддэг байсан | 58,3 | 41,7 | 71,1 | 28,9 | 72,9 | 27,1 | 82,6 | 17,4 | 86,5 | 13,5 |


Харин дээрх үзүүлэлт сургуулийн өмчлөл, байршлаас шалтгаалж нийт үр дүнгээс онцын өөрчлөлтгүй байв. Доорх хүснэгтээс сургуулийн өмчлөлөөс хамаарч зайны сургалтад бэлтгэлтэй байгаагүй, харин ч холимог өмчит байх тусмаа үзүүлэлт бага зэрэг өссөн буйг харж болно. .

Хүснэгт 17. Зайны сургалтад бэлэн байсан эсэх/Сургуулийн өмчлөлөөр/

| | Төрийн | | Хувийн | | Холимог | |
|---|--------|------|--------|------|---------|------|
| | тийм | үгүй | тийм | үгүй | тийм | үгүй |
| Өмнө нь зайнаас хичээл зааж үзсэн байсан | 24,8 | 75,2 | 30 | 70 | 22,2 | 77,8 |
| Өмнө нь зайны сургалт хийх чадвар олгох сургалтад хамрагдсан байсан | 23,3 | 76,7 | 20,9 | 79,1 | 44,4 | 55,6 |
| Цахим хэрэгсэлтэй хангалттай ажиллаж чадаж байсан | 80,2 | 19,8 | 80 | 20 | 88,9 | 11,1 |
| Цахим орчны программ ашиглаж мэддэг байсан | 74 | 26 | 76,3 | 23,7 | 77,8 | 22,2 |


Зайны сургалт эхлэх үед дээр дурдсан байдалтай байсан бол зайны сургалтын төгсгөлд оролцогчдод шинээр суралцсан ур чадвар буй эсэхийг дараах дөрвөн үзүүлэлтээр хэмжихэд “цахим орчинд ажиллах, цахим хичээл заахад шаардлагатай хэрэгсэлтэй ажиллах, харилцаа холбооны шинэ арга хэрэгсэлтэй ажиллах” чадварууд тэр дундаа “хичээл заах арга барилдаа өөрчлөлт оруулсан” гэх үзүүлэлт өсөлттэй харагдаж байна.

График 13. Суралцсан шинэ чадвар



Үүнийг сургуулийн байршил, шатлалаар задлан харвал дараах үр дүн гарчээ. Үүнд зөвхөн “сайн, маш сайн” гэх үзүүлэлтийг нэгтгэн харууллаа.

График 13. Суралцсан шинэ чадвар /Сургуулийн шатлалаар/



Хүснэгт 18. Суралцсан шинэ чадвар /Сургуулийн байршлаар/

| | Цахим орчинд ажиллах чадвар нэмэгдсэн | Цахим хэрэгсэлтэй ажиллах чадвар нэмэгдсэн | Харилцаа холбооны шинэ арга хэрэгслийг эзэмшсэн | Хичээл заах арга барилдаа өөрчлөлт оруулсан |
|-------------------------------|---------------------------------------|--|---|---|
| Баянзүрх, Сонгинохайрхан | 72.6 | 76,8 | 69,5 | 69,5 |
| Сүхбаатар, Хан Уул | 53,5 | 58 | 71,3 | 54,2 |
| Чингэлтэй, Баянгол | 61,5 | 66.6 | 61,6 | 69,2 |
| Багануур, Багахангай, Налайх, | 75 | 75 | 69,4 | 75 |

| | | | | |
|--|------|------|------|------|
| Баруун бүс/Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ | 65.8 | 68,5 | 55.3 | 58 |
| Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/ | 80 | 75 | 65 | 75 |
| Төвийн бүс /Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/ | 68,9 | 70,7 | 62,9 | 65,5 |
| Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ | 60,2 | 61,8 | 58.5 | 54,4 |

Зарим талаар энэхүү хөл хорионы үе дэх зайны сургалт багш нарт өмнө эзэмшүүлж чадаагүй шинэ арга барилд суралцах үе байсан буюу цаашдаа хэрэгжүүлж болох зайны сургалтын дадлага ажил болсон гэж дүгнэж болох юм.

3.2. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН СУРАЛЦАХУЙ

Суралцахууд “Ковид-19” цар тахлын үзүүлсэн нөлөөг зөвхөн багшийн үнэлэмжээр, дараах үзүүлэлтээр тодруулсан юм. Үүнд:

- Суралцагчтай холбогдсон давтамж;
- Тулгамдаж асуудал;
- Бие даан суралцах чадвар;
- Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг.

3.2.1. Суралцагчтай холбогдсон давтамж

Оролцогчдын 30% нь суралцагчидтайгаа өдөр бүр, мөн 30% орчим нь долоо хоногт нэгээс хоёр удаа, 9.5% нь сард нэгээс хоёр удаа холбогдсон бол 11.5% нь огт “холбоо бариагүй” гэжээ. Оролцогчдын зүгээс суралцагчидтайгаа холбогдох ажил ихээхэн бэрхшээл дагуулж байсныг өмнө дурдсан тэдний “ажлын ачаалал ихэссэн” гэх хариултын үндсэн шалтгаанаар дурдсанаас мөн харж болно.


График 14. Суралцагчидтайгаа холбогдсон давтамж



Үүнийг сургуулийн шатлалаар нарийвчлан харвал сургуулийн өмнөх, дээд сургуулийн багш нар сурагчидтайгаа “долоо хоногт нэгээс гурван” удаа холбоо


барих нь дундаж үзүүлэлт байсан бол бага, дунд сургуулийн багш нар “өдөр бүр” эсхүл “долоо хоногт нэгээс гурван” удаа холбогдож байжээ. Гэхдээ “сард нэгээс хоёр удаа” эсхүл “огт холбоо бариагүй” суралцагчид ч байсан талаар шатлалаас үл хамаарч оролцогчдын 10 илүү хувь хариулжээ.

График 15. Суралцагчидтайгаа холбогдсон давтамж /сургуулийн шатлалаар/



Бага, дунд сургуулийн багш нарын хувьд суралцагчидтай тогтмол холбогдох зайлшгүй шаардлагатай байсан нь зүй ёсных бөгөөд багш нар утсаар, цахимаар болон гэрээр нь биечлэн явж уулзаж байсныг судалгаанд оролцогчид мөн дурдаж байв.

График 16. Суралцагчидтайгаа холбогдсон давтамж /сургуулийн байршлаар/



Суралцагчидтай холбогдсон давтамж нийслэлийн оролцогчдын хувьд өндөр байх агаад орон нутагт нийслэлээс харьцангуй бага буй нь газар байршил, малчин өрхийн хүүхэд зэрэгтэй холбоотой юм. “Огт холбоо бариагүй сурагчид ч бий” гэх үзүүлэлтийг баруун бүсийн аймгууд болох Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховдоос оролцогчдын 23,7 хувь нь, төвийн бүсийн аймгууд болох Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төвөөс оролцогчдын 15 хувь нь сонгосон нь аймгууд дундаа өндөр үзүүлэлт бол нийслэлээс Чингэлтэй, Баянгол дүүргээс оролцогчдын 13 орчим хувь нь сонгосон нь нийслэл дундаа өндөр үзүүлэлт байв.

3.2.2. Тулгамдсан асуудал

Зайны сургалтын үеэр суралцагчдад тулгарч буй асуудлын талаар болон өөрсдийн санаа зовинож байсан асуудлын талаар багш нар дараах байдлаар хариулсныг давтамжийн эрэмбээр жагсаав.


Хүснэгт 19. Суралцахууд тулгамдаж байсан асуудал

| Суралцахууд тулгамдаж байсан асуудал | |
|--------------------------------------|---|
| 1 | Сурагчид интернэтэд холбогдох боломжгүй байсан. Интернэт суурилуулах, дата төлбөр төлөх боломжгүй, эсхүл ухаалаг утас, хэрэгсэлгүй сурагчид олон байсан. Зурагт, антенгүй эсвэл теле хичээл үзэх боломжтой байлаа ч түүнийгээ багшид шалгуулах, даалгавраа илгээх гэхээр интернэтгүй айл зөндөө байв. |
| 2 | Олон хүүхэдтэй айлын сурагчид тэр бүр теле хичээл үзэх боломжгүй байсан. Ангиудын хичээл давхцаж байсан, айлд гэтэл ганцхан зурагт байдаг, хөтөлбөр нөхөж үзэх боломжгүй айл зөндөө байдаг. |
| 3 | Дунд, ахлах ангийн сурагчид гэрийн ажилд дарагдах, дүү нараа харах зэргээр хичээл хийх завгүй байсан. |
| 4 | Малчин айлын хүүхэдтэй холбогдох боломжгүй байв. Сүлжээгүй газар байх, хавар таарсан учир ид мал төллөх, ямаа самнах зэргээр ачаалалтай үе учраас холбогдож чадаагүй сурагчид олон бий. |
| 5 | Эцэг, эхийн хараа хяналт сул хүүхдүүд гар утсанд донтох, интернетийн буруу хэрэглээнд орох вий хэмэн санаа зовж байсан. |
| 6 | Цахим, теле хичээлийг бататгах, даалгаврын гүйцэтгэлийн хянах боломж муу, сурагчдын эргэх холбоо сул байсан тул сэдвийг бүрэн гүйцэт ойлгосон эсэх нь тодорхойгүй байсан. |
| 7 | Эцэг эхчүүдтэй харилцах хүндрэлтэй байв. Ялангуяа бага ангийн хүүхдэд даалгавар өгнө гэдэг бол эцэг, эхэд ч мөн өгч буй хэрэг, гэтэл эцэг, эхчүүд хангалттай хамтарч ажиллахгүй байлаа. |
| 8 | Сурагчдын бие даан суралцах чадвар сул байлаа. |
| 9 | Теле хичээлийн хурдыг гүйцэхгүй, ухраах-зогсоох-нөхөж үзэх боломжгүй сурагчид олон байв. Ер нь теле хичээлийн агуулга сурлагадаа сайн хүүхдэд зориулсан, хурдтай байлаа. |
| 10 | Теле хичээл ер нь үр дүнгүй байсан тул санаа зовж байв. |
| 11 | Номын сангууд мөн хаалттай тул сурагчдад хэрэглэх, сэдвийг дэлгэрүүлэх гарын авлага, ном хангалтгүй байсан. |
| 12 | Ангидаа хэвшил болгосон байсан олон ажлууд, тухайлбал “Номын богц”, “Найзаа магъя” зэрэг олон сайн аргууд тасарсан. |
| 13 | Удаан ойлгоцтой, математикийн хичээлийн хоцрогдолтой байсан хүүхдүүд бүүр ч их хоцрогдсон. |
| 14 | Хэл, ярианы бэрхшээл, хоцрогдолтой байсан сурагчидтай тулж ажиллах боломжгүй болсон. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хэрхэх тухай асуудал бүр мөсөн орхигдсон. |
| 15 | Нийт сурагчдын агуулгын хоцрогдол, бие бялдрын хөгжилд санаа зовж байсан |

Эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хэрэгтэй, тэд нь хичээлийг давтуулах, даалгаврыг багшид илгээх шаардлагатай болдог тул бага ангийн сурагчдын багш нарт энэ үед суралцагчидтайгаа төдийгүй эцэг эх, асран хамгаалагчидтай ажиллах давхар бэрхшээл учирч байсан нь зарим талаар хүндрэлтэй байжээ.

Түүнчлэн зайны сургалтын үеэр багш нар малчин өрхийн хүүхэд, ядуу, эмзэг бүлгийн хүүхдүүдийн хэрхэн суралцаж буйд түлхүү санаа зовж байжээ. Эдгээр бүлгийн хүүхдүүдэд зайнаас суралцах, теле болон цахим хичээл үзэх боломж бололцоо тааруу байсанг багш нар мөн дурдаж байлаа.

График 17. Суралцахууд нь санаа зовсон суралцагч



“Бусад” гэх шалтгаанд дараахыг дурджээ.

Хүснэгт 20. Суралцахууд нь санаа зовсон суралцагч

| | |
|----|---|
| 1 | Агуулгын хоцрогдолтой хүүхэд |
| 2 | Бие даан суралцах чадвар сул хүүхэд (дунд, ахлах ангийн) |
| 3 | Танхимд дуугардаггүй, багшийн шаардлагаар юм хийдэг суралцагчид |
| 4 | Ойлгоц удаан хүүхэд |
| 5 | Сурах арга барил удаан хүүхэд |
| 6 | Эцэг, эх нь хоёулаа завгүй ажилладаг хүүхэд |
| 7 | Эцэг, эх нь гадаадад байдаг, эсвэл гадаадад түгжигдсэн айлын хүүхэд |
| 8 | Эцэг эх нь салсан, эсвэл өнчин учраас өвөө, эмээ болон бусад айлд байдаг хүүхэд |
| 9 | Ам бүл олуул, дүүгээ хардаг хүүхэд |
| 10 | Харах хүнгүй үлдэж байсан хүүхэд |
| 11 | Нөхцөл байдлыг ойлгож тусалж дэмжиж хамтран ажилладаггүй, харилцаа хандлага муу шүүмжлэхийг урьтал болгодог эцэг эхтэй хүүхэд |
| 12 | Бие даан суралцах чадвар хараахан суугаагүй буюу бага ангийн хүүхэд |


Дээрх хариултыг хүйс, сургуулийн байршил, шатлал, өмчлөлөөр задлан харахад нийт дүнгээс зөрүүгүй ба эмэгтэй багш нар суралцагчдад тулгарсан, санаа зовсон асуудлыг түлхүү хариулан оролцжээ. Цаашдаа зайны сургалтын үед

дээрх бүлгийн хүүхдүүдэд зориулсан тусгай бодлого шаардлагатай нь харагдаж байна.

3.2.3. Бие даан суралцах чадвар

Суралцагчдын бие даан суралцах чадвар ямаршуу түвшинд байсныг оролцогчдоор нэгээс найм хүртэлх түвшнээр үнэлүүлсэн юм. “О” үнэлгээ хамгийн муу, “100” үнэлгээ хамгийн сайн үнэлгээ байсан ба оролцогчдын 37.8% нь 59 онооноос багаар, 50% нь 60-79 оноо хүртэл түвшнээр үнэлжээ. Нийтдээ оролцогчдын 38% орчим 0-59 хүртэл, 50% орчим нь 60-79 хүртэл, үлдэх нь 80-100 хүртэлх оноогоор суралцагчдыг дүгнэжээ. Энэ үзүүлэлт оролцогчдын хүйс, сургуулийн байршил, шатлал, өмчлөлөөс шалтгаалж нэгдсэн дүнтэй онц зөрөөгүй байна.


График 18. Суралцагчдын бие даан суралцах чадвар



3.2.4. Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг


Оролцогчдын 55.7% нь эцэг эх, асран хамгаалагчтай харилцах харилцаанд ямар нэг “өөрчлөлт ороогүй” гэсэн бол “ээрэгээр өөрчлөгдсөн” хэмээн 35.9% нь, “таагүй харилцаатай болсон” хэмээн 8.3% нь үзжээ.

График 19. Эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаанд өөрчлөлт орсон байдал



Үүнийг сургуулийн шатлалаар задлан харвал бага, дунд сургуулийн оролцогчдын эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаа илүүтэй эерэгээр өөрчлөгдсөн байна. Бусад шатлалын сургуулийн хувьд эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах боломж угаас хязгаарлагдмал, зарим тохиолдолд шаардлагагүй байдаг гэдгээ дурдсан байна..

График 20. Эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаанд өөрчлөлт орсон байдал /сургуулийн шатлалаар/



Энэхүү өөрчлөлтийн шалтгааныг оролцогчид дараах байдлаар хариулсныг хамгийн олон давтагдсан эрэмбээр харуулж байна.


Хүснэгт 21. Эерэг, сөрөг өөрчлөлтийн шалтгаан.

| Эерэг өөрчлөлтийн шалтгаан | Сөрөг өөрчлөлтийн шалтгаан |
|--|---|
| Олон дахин холбогдоход нааштай хандсан. | Олон дахин холбогдоход дургүйцсэн. |
| Гэрээр очиж уулзан, дасгал, даалгавар өгөхөд маш их баярласан. | Сургалтын төлбөр нэхэх, сургалтын төлбөр хөнгөлөөгүүд дургүйцсэн. |

| | |
|---|--|
| Зөвхөн эцэг эхийн хурлаар л уулздаг байсан бол одоо байнга холбогдож, хоорондоо илүү танилцаж буй учраас хэн хэнд нь таатай байсан. | Даалгаврыг нь хийлгэж амжихгүй байна, та нар шиг өдөржин гэртээ байгаа биш гэх зэргээр дургүйцэх хандлага цөөн бус байсан. |
| Өдөр бүр хүүхдэдээ хэрхэн тухайн өдрийн агуулгыг заах талаар зөвлөмж хүргүүлж байсан учраас | Хүүхдийг хэт их хичээлээр дарсан, хичээл хийхэд нь дэмжлэг үзүүлээрэй гэх мэт зөвлөгөөнд түүртээд маргаан үүсгэсэн. |
| Өдөр бүр хүүхэдтэйгээ хамт байж, багшийн ажлын ачааллыг мэдэрсэн учраас | Даалгавар их өгсөн, хүүхдийг Facebook ашиглахыг шаардсан, утсанд донтууллаа гэж дургүйцсэн. |
| | Төгсөх анги байхад цуглуулж хичээллүүлэхийг шаардаж уурлаж байсан. |
| | “Улсаас амар гэсэн байхад та нар л хичээлээр дарлаа” гэх зэргээр зайн сургалтыг ойлгоогүй байсан. |

Оролцогчдын 45.3% зайны сургалтын үеэр эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ “бага зэрэг” тусалсан, 12% нь “огт туслаагүй” буюу багш нарын 58% орчим нь эцэг эхчүүдийн оролцоонд сэтгэл хангалуун бус байжээ. Энэ үр дүн нь хүүхдийг сургах ачаалал багшийн нуруун дээр хэвээр л байсныг илтгэх ба нөгөө талдаа зайны сургалтын чанарт нөлөөлөхүйц хэмжээнд байгааг анхаарууштай.

График 21. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ тусалж чадсан эсэх



Уг үзүүлэлтийг сургуулийн шатлалаар харвал оролцогчдын олонх, тэр дундаа бага, дунд сургуулийн багш нар эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ “хангалтай хэмжээнд туслаагүй” гэж үзсэн байх ба үүнийг лавшруулан тэдэнд ямар чадвар дутагдсан талаар оролцогчид “хүүхдэдээ цаг гаргах, цахим орчинд ажиллах, техник технологийн чадвар дутагдсан” хэмээн оролцогчдын 80-90% орчим нь үзжээ. Мөн түүнчлэн “эерэг хүмүүжлийн болоод багштай эерэг харилцах чадвар дутсан” хэмээн оролцогчдын 50- 70% орчим нь мөн үзжээ.

График 22. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ тусалж чадсан эсэх /сургуулийн шатлалаар/





График 23. Эцэг эх, асран хамгаалагчдад дутагдсан чадвар



Үүнээс сургуулийн шатлалаар задлан, зөвхөн “тийм” гэх хариултыг онцолбол дараах үзүүлэлт гарчээ. Эцэг эх, асран хамгаалагчидтай байнга харилцах шаардлага гардаг сургуулийн өмнөх болон бага, дунд сургуулийн багш нарын хариултыг онцоллоо.

Хүснэгт 22. Эцэг эх, асран хамгаалагчдад дутагдсан чадвар /сургуулийн шатлалаар/

| | Сургуулийн өмнөх | Бага | Дунд |
|-----------------------------------|------------------|------|------|
| Багштай зэрэг харилцах | 33,3 | 50 | 44 |
| Хүүхэдтэйгээ хичээллэх цаг гаргах | 66,7 | 84,2 | 89,8 |
| Цахим орчинд ажиллах | 75 | 73,7 | 77,8 |
| Техник технологийн | 83,3 | 75 | 75,7 |
| Эерэг хүмүүжлийн | 66 | 77,6 | 73,9 |


Үүнээс сургуулийн байршлаар задлан, зөвхөн “тийм” гэх хариултыг онцолбол дараах үзүүлэлт гарчээ. Баруун бүсгийн аймгууд болоод нийслэлийн хамгийн хүн амын төвлөрөл өндөр дүүргүүд болох Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд зарим үзүүлэлт 90-ээс өндөр хувьтай байна.

Хүснэгт 23. Эцэг эх, асран хамгаалагчдад дутагдсан чадвар
/сургуулийн байршлаар/

| | Багштай эерэг харилцах | Хүүхэд-тэйгээ хичээллэх цаг гаргах | Цахим орчинд ажиллах | Техник технологийн | Эерэг хүмүүжлийн | Дундаж дүн |
|---|------------------------|------------------------------------|----------------------|--------------------|------------------|--------------|
| Баянзүрх, Сонгинохайрхан | 64,2 | 94,8 | 87,3 | 83,2 | 76,8 | 81,26 |
| Сүхбаатар, Хан Уул | 59,6 | 83,2 | 77,8 | 77,9 | 71,7 | 74.04 |
| Чингэлтэй, Баянгол | 70,7 | 89,8 | 76,9 | 61,5 | 68,2 | 73.42 |
| Багануур, Багахангай, Налайх, | 61,1 | 88,9 | 91,7 | 80,6 | 80,6 | 80.58 |
| Баруун бүс/Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ | 55,3 | 89,4 | 94,7 | 86,6 | 81,6 | 81.52 |
| Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/ | 60 | 80 | 85 | 85 | 75 | 81.12 |
| Төвийн бүс / Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/ | 58,9 | 91,4 | 86,3 | 89,7 | 79,3 | 81.12 |
| Хангайн бүс / Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ | 55,8 | 88,2 | 86,5 | 82,4 | 64,7 | 75.52 |

Харин оролцогчид хөл хорионы үе дэх суралцагчдын нөхцөл байдлыг дараах байдлаар үнэлжээ. Оролцогчдын 24% орчим нь суралцагчдын хоол тэжээл хангалттай байсан эсэх болон аюулгүй байдлын талаар “мэдэхгүй” гэсэн бол мөн тэнцүү хувиар “ер нь болон маш хангалтгүй” хэмээжээ. Харин оролцогчдын 35.7% нь нийт асуултад “ер нь хангалтгүй”, 4.5% нь “маш хангалтгүй”, нийтдээ оролцогчдын 40% орчим нь сурагчдын нөхцөл байдалд тааруу үнэлгээ өгчээ. Оролцогчдын 35.7% нь нийт асуултад “хэвийн”, 11% нь “сайн” буюу нийт дүнгээр 46% нь суралцагчдын нөхцөл байдал “хэвийн эсхүл сайн” байсан гэжээ. Оролцогчдын 9.3% нь харин нийт асуултад “мэдэхгүй” хэмээн хариулжээ.

График 24. Суралцагчдын нөхцөл байдал



Энэ үзүүлэлт оролцогчдын хүйс, сургуулийн байршил, шатлал, өмчлөлөөс шалтгаалж нэгдсэн дүнтэй онц зөрөөгүй гарсан юм.

3.3. ДАРААГИЙН ХӨЛ ХОРИОНЫ НӨХЦӨЛД АЖИЛЛАХАД БЭЛЭН ЭСЭХ

Дэлхий даяар “КОВИД-19”-ын дэгдэлт буураагүй, урьдчилан сэргийлэх вакцин гараагүй учир ахин хөл хорио тогтоох, зайнаас ажиллах эрсдэл байсаар буй юм. Ахин хөл хорио зарлаж, зайнаас ажиллах нөхцөл үүсвэл хэрхэн талаар асуухад олонх багш нар “халдвар хамгааллын дэглэмээ сайн сахиж, танхимын сургалт хийх” хүсэлтэй буйгаа дурдсан юм. Үүний шалтгаан нь зайнаас сургалт явуулах тийм ч үр дүнтэй байгаагүй, мөн өмнөх хэсгүүдэд дурдсан шалтгаанаар зайны сургалт тэдэнд хүндрэлтэй байгаад оршиж байна. Түүнчлэн хөдөө орон нутаг утас, интернэтийн сүлжээ болоод тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдлыг харгалзсан бодлого хэрэгжүүлэхийг удаа дараа сануулж байв. Зайлшгүй зайнаас хичээллэх болвол шаардлагатай зүйлсийг давтамжаар жагсаан харуулбал:

Хүснэгт 24. Зайнаас хичээллэхэд шаардлагатай зүйлс

| Шаардлагатай зүйлс | |
|--------------------|---|
| 1 | Цахим хичээлийн нэгдсэн платформ бий болгох |
| 2 | Цахим сургалтын арга зүй, нэгдсэн зөвлөмжөөр хангах |
| 3 | Урьдчилан бэлтгэсэн цахим хичээл, даалгаврын сан бүрдүүлэх |
| 4 | Цахим хичээл бэлтгэх сургалтад хамруулах (агуулга, арга зүйгээс гадна тоног төхөөрөмж, программ ашиглах талаар) |
| 5 | Суралцагчийг зайнаас үнэлэх үнэлгээний шинэ арга зүй боловсруулах |
| 6 | Багш нарыг үнэлэх арга зүй боловсруулах, (цахим хичээлийг ердийн хичээлтэй адилтгах эсэх талаар) |
| 7 | Сургууль, дүүрэг аймгийн боловсролын газар, Боловсролын яам нэгдсэн арга зүйгээр, маш тодорхой удирдах (гэнэтийн шийдвэр гаргахгүй байх, багш нараас шаарддаг тайлан, бичиг цаасыг багасгах) |
| 8 | Техник хэрэгсл, сургалтын материалаар (зөөврийн компьютер, камер, камерийн хөл, гэрт байршуулах самбар, бичгийн цаас) хангах |
| 9 | Багш төдийгүй оюутан, суралцагчдад интернэт, дата, утасны төлбөр олгох, гэр хороолол, хөдөө орон нутагт интернэтийн сүлжээтэй болгох |
| 10 | Сурагчдын гэрээр очиж ажиллах үед унаагаар хангах |
| 11 | Эцэг эхийн дэмжлэг хэрэгтэй тул зөвхөн багш нарт гэлтгүй эцэг эхчүүдэд зориулсан зайны сургалтын гарын авлага боловсруулж өгөх |
| 12 | Эцэг эхчүүдтэй шинэчилсэн журмаар гэрээ байгуулах |
| 13 | Цалин хөлс нэмэх, ажлын ачаалал буурахгүй байгаа тул илүү цагийн гэх мэт нэмэгдэл хөлсийг хасахгүй байх. |
| 14 | Багш нарт гэрээсээ төдийгүй сургуулиасаа ажиллах боломж олгох. |

Энэхүү судалгааг 2020-2021 оны хичээлийн жил эхлэхээс өмнө авсан багш нар 100 хувь хичээлийн хоцрогдлыг хэрхэн нөхөх талаар санаа зовиож байсан ба өмнөх жилүүдийн танхимын буюу хэвийн үеийн хичээлийн жилээс ч илүү ачаалалтай ажиллахаа мэдэж байв. Энэ хариултыг мөшгин оролцогчдоос 2020 оны 10 дугаар сард ахин асуухад дараах хариултыг өгснийг давтамжаар эрэмбэлэн харууллаа.

Хүснэгт 25. 2020-2021 оны хичээлийн жилийн эхний улиралд тулгарч буй бэрхшээл

| Тулгарч буй бэрхшээл | |
|----------------------|---|
| 1 | Суралцагчдын агуулгын хоцрогдол маш их. |
| 2 | Суралцагчдын анхаарал төвлөрөх, суух чадвар буурсан. |
| 3 | Суралцагчдын олонх нь илүүдэл жинтэй, гар утсанд донтох хандлагатай болсон байна. |

| | |
|----|---|
| 4 | Хоцрогдол арилгах давтлага өгөхийг хүсч буй ч анги, танхим хүрэлцээгүй. |
| 5 | Нэг ангийн хүүхдийн тоо их буй тул хүүхэд бүртэй тулж ажиллаж чадахгүй байна. |
| 6 | Зөвхөн хоцрогдол арилгахдаа төвлөрч ажилламаар байвч сургуулийн удирдлага, яамнаас тайлан, мэдээ, шалгалт зэргээр хэрэгцээгүй, бичиг цаасны ажлаар их дарж байна |
| 7 | Багш, суралцагч нарт хандсан илтгэл, ур чадварын тэмцээн, олимпиад, аян зохион байгуулах удирдамж тасрахгүй байгаа нь суралцагчидтайгаа тулж ажиллах цагаас хомсолж байна. |
| 8 | Удаан танхимд хичээллээгүй, хичээлийн ачаалал их байгаа учир суралцагчид ядарч, идэвх буурсан байдалтай байна. Гэтэл нэгдүгээр улирлын амралтыг хойшлуулсан нь сөрөг үр дүн үзүүлж байна. |
| 9 | Танхимаар удаан хичээллээгүй, хоцрогдол арилгах гэж оролдож байхад суралцагчдаас удаа дараалан шалгалт авч, тэр нь эргээд багш нарт ачаалал нэмж байна. |
| 10 | Эцэг эхчүүд хангалттай хамтарч ажиллахгүй байна. Хичээлийн хоцрогдол арилгах нь зөвхөн багш дангаараа хүчрэх ажил биш. |

3.4. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

Дэлхий нийтийг хамарсан "КОВИД-19" цар тахлын нөлөө 1.6 тэрбум суралцагч, 63 сая багш нарт шууд сөргөөр нөлөөлсөн тоон мэдээ байна.³ Сургууль хаагдах үеийн сургалтыг цахим, теле хичээлээр нөхөх оролдлого тулгарсан ч бодит байдалдаа суралцагч төдийгүй багш нарт шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр дутмаг байсан нь олон судалгаагаар илэрсэнг ЮНЕСКО (Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага) мэдээлсэн юм. Тухайлбал, нийт суралцагчдын 50% орчим нь интернэт болон интернэтэд холбогдох төхөөрөмжгүй байжээ. Багш нарын хувьд ч ялгаагүй интернэт, түүнд холбогдох төхөөрөмж дутмаг, түүнчлэн зайнаас хичээллэж байгааөөрсдийн хүүхдээ харж хандахын хажуугаар суралцагчдынхаа "тасралтгүй суралцах эрх"-ийг хангахын тулд урьд урьдаас илүү ачаалалтай ч чимээгүйхнээр ажиллаж байв. Тулгарч буй, цаашдаа тулгарч мэдэх хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудын нөхцөл байдлыг дээрдүүлэх талаар салбарын байгууллагуудаас зөвлөмж, дэмжлэг гаргаж буйн заримаас энд хуваалцаж байна.

Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь, ЮНЕСКО

ЮНЕСКО-оос багш, хичээлийн эрхлэгч, боловсролын салбарын ажилтнуудыг хамгаалах, дэмжих, өнөөгийн тулгамдаад буй эрүүл мэндийн хямралтай тэмцэх хариу арга хэмжээнд тэдний оруулж буй хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрөхийг

3 UNESCO., "World Teachers' Day 2020 Teachers: Leading in crisis, reimagining the future", 2020. (сүүлд үзсэн 2020.10.05)

уриалж байгаа юм. Энэ дагуу “КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын хариу арга хэмжээ” боловсруулж, хэд хэдэн зөвлөмж гаргасны нэг нь “Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь” юм.⁴ Уг зөвлөмжид дурдсанаар “КОВИД-19”-ийн үед засгийн газрууд, бусад томоохон байгууллагууд дараах асуудлын хүрээнд багш, боловсролын салбарын ажилтнуудад тусламж, дэмжлэх үзүүлэх шаардлагатайг онцолжээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсийг хадгалан үлдэх;

- Багш, суралцагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг чухалчлах;
- “КОВИД-19”-ийн эсрэг хариу арга хэмжээг боловсруулах үйл явцад багш нарыг татан оролцуулах;
- Багш нарт мэргэжлийн зохих дэмжлэг үзүүлэх, сургалтанд хамруулах;
- Тэгш боломжийг боловсролын хариу арга хэмжээний үндсэн зорилго болгох;
- Багш, боловсролын салбарын ажилтнуудад тусламж, дэмжлэх үзүүлэх арга хэмжээнд багш нарыг өөрсдийг нь оролцуулах зэрэг болно.

Уг баримт бичигт онцолж буйгаар багш, боловсролын салбарын ажилтан нь үйлчилгээ үзүүлэгч байгаад зогсохгүй эрх эдлэгч бөгөөд боловсролын эерэг шинэчлэлийн хүчтэй нэг оролцогч учраас тэд “КОВИД-19” цар тахлын үеийн хямралын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөхөд оролцох ёстой. Түүнчлэн багш нарын хэрэгцээ, чадавх, тэдэнд дутагдаж буй зүйлсийн талаар мэдээлэл цуглуулах нь чухал ба ингэхдээ:

- **Богино хугацаанд:**

- Багш нарын чадавх, тэдгээрийн мэргэжлийн, санхүүгийн болон нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөлийн хэрэгцээг тодорхойлох, баримтжуулах;
- Сургуулиудын үйл ажиллагаа дахин хэвийн болох үед боловсролын хангамжийн болон сургалтын дутагдал хаана байгааг тодорхойлж, баримтжуулах;⁵
- Боломжтой нөхцөлд, багш нарт цар тахлын үзүүлж буй сөрөг үр нөлөөг илүү ойлгох, шийдвэрлэхийн тулд багш нарын мэдээллийг жендэр, байршил болон бусад үзүүлэлтээр нь нарийвчлан задлах.

- **Дунд болон урт хугацаанд:**

- Бодлого боловсруулагч, төлөвлөгч, хэрэгжүүлэгч нар нь ирээдүйн хямралын эсрэг хариу арга хэмжээ авахдаа мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад илүү туршлагатай байхын тулд Багшийн удирдлагын

4 Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь, https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373338_mon (сүүлд үзсэн 2020.10.17)

5 Үүнд “Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь” зөвлөмжийн ЮНЕСКО-оос гаргасан монгол орчуулгыг баримталсан ба англи эх хувьтай тулган нягтлахыг зөвлөж байна. Үндсэн эхэд “*Identify and document where there are gaps in education provision and learning to be urgently addressed once schools reopen*” хэмээсэн буй.

мэдээллийн системийг хөгжүүлэх/засварлах замаар багш нарын талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулах ажлыг системчлэх гэсэн юм. Энэхүү “Багшлах, суралцах үйлд “Ковид-19” цар тахлын үзүүлсэн нөлөө” бичил судалгаа нь ч мөн дээрх зорилгын дагуу хийгдсэн юм.

Зайн сургалтын шийдэл, ЮНЕСКО

ЮНЕСКО-оос багш, эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад зориулан зайн сургалтын шийдэл бүхий орон орны 100 орчим цахим эх сурвалжийг нэгтгэн мэдээлсэн юм.⁶ Үүнд:

- Гар утсанд зориулсан систем;
- Интернэтгүй үед хэрэглэх боломжтой систем;
- Багаар ажиллах боломжтой цахим систем;
- Бие даан, ганцаарчлан ажиллах боломжтой цахим систем;
- Видеогоор холбогдон багаар ажиллах боломжтой цахим систем;
- Багш нарт зориулсан цахим хичээл бэлтгэх систем;
- Зайн сургалтын агуулга бүхий систем;
- Цахим сургалтын менежментийн систем;

Эдгээр зайн сургалтын агуулгад теле, цахимаас гадна радиогоор хийх сургалтын агуулга буйг анхаарвал зохино.

Сургуулийн удирдлагад зориулсан “Сургууль эргэн нээх үед багш нарт туслах нь” гарын авлага, Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, ЮНЕСКО ⁷

Энэхүү гарын авлагад сургуулийг эргэн нээх үед сургуулийн удирдлагууд анхаарах ёстой зүйлс, энэ дагуу сургууль, сургалтын нөхцөл байдлаа үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргасан юм. Үүнд:

1. Олон нийтийн хэлэлцүүлэг, байр суурь;
2. Эрүүл мэнд, аюулгүй байдал;
3. Багшийн биеийн болоод сэтгэцийн эрүүл мэнд;
4. Багшийн багшлах бэлтгэлийг хангах, сургах;
5. Багшийн эрх, үүрэг, ажиллах нөхцөл;
6. Санхүү, хөрөнгө оруулалт;
7. Хяналт, үнэлгээ.

Тухайлбал, багшийн эрх, үүргийг тодорхой болгох, ажиллах нөхцлийг дэмжих үүднээс сургуулийн удирдлага дараах шалгуурыг анхаарах ёстой талаар уг гарын авлагад ийн дурджээ.

⁶ Зайн сургалтын шийдэл, <https://en.unesco.org/covid19/educationresponse/solutions> (сүүлд үзсэн 2020.10.17)

⁷ <https://teachertaskforce.org/knowledge-hub/supporting-teachers-back-school-efforts-toolkit-school-leaders> (сүүлд үзсэн 2020.10.17)

Та дараах нөхцлийг харгалзаж үзсэн үү?

- Багш нарын цалин, нөхөн төлбөр, урамшуулал, ажлын хуваарь, бусад ажиллахад шаардлагатай нөхцлийг тооцсон эсэх?
- “Ковид-19”-ийн үед ажиллах багш, туслах ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын чанарыг үнэлэх аргачлалыг бий болгосон эсэх?
- “Ковид-19”-ийн үед ажиллах багш, туслах ажилтнуудыг дэмжих талаар төлөвлөгөө боловсруулсан уу? Үүнийгээ орон нутгийн, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн үү? Тэднээс ямар дэмжлэг хүсч буйгаа тодорхойлсон уу?
- “Ковид-19”-ийн үед ажиллах багш, туслах ажилтнуудыг гүйцэтгэлийн чанарыг үнэлэх арга зүйгээ өөрчилж, шинэчлэсэн үү?

Зөвлөмж:

- **Багшийг шалгаж, үнэлэхээ түр хойшлуул.** Багшийн хянаж шалгах, үнэлгээ тавихаа түр хойшлуулбал сайн. Багш нарт шинэ нөхцөлд ажиллаж дадахад хугацаа хэрэгтэй. Үнэхээр үнэлэх шаардлагатай бол тэр нь энэ хямралын үед багшид бүх хүүхэдтэй ажиллах, суралцах нийгэм-сэтгэцийн боломж бий болгоход анхаарсан эсэхт л чиглэж байвал зохино.
- **Багшийг урамшуул.** Сургуулийн удирдлага гэлтгүй боловсролын бүхий л байгууллагууд багш, бусад ажилтнуудын цалин хөлсийг цаг тухайд нь, бүрэн бүтэн олгох, тэдгээрт өөрсдийнхөө ажлыг ач холбогдлыг мэдрүүлэх, урам зоригтой ажиллах нөхцлийг бүрдүүлэх талаар анхаарах ёстой. Ялангуяа боловсролын салбар бол эмэгтэйчүүд давамгайлсан салбар гэдгийг анхаарах, тэдгээрт чиглэсэн бодлого хэрэгжүүлэх ёстой.

Сургуулийн удирдлагын сайн туршлага

Багшийг дэмжих тийм ч хэцүү биш.

Индонези улсад сургууль хаасан үеэр нэг багш “зарим багш нар цахим хичээл заах, сурагчдын асуултад хариулах зэргээр долоо хоногт 80-аас илүү цаг ажиллаж” буй талаар мэдэгдсэн юм. Энэ дагуу сургуулийн удирдлагаас суралцагч болоод тэдний эцэг эхчүүдэд зориулсан тусдаа групп чат үүсгэж, тэдгээрийг туслах ажилтнуудад хариуцуулсан нь багшийн ачааллыг бууруулах, буруу, дутуу ойлголттой үлдэхээс сэргийлсэн юм.

Оман улсад нэгэн сургуулийн удирдлага сургуультай холбоотой сошиал групп, групп чатын тоог хянах, нэгдсэн групп ажиллуулснаар багш нарын суралцагч, тэдний эцэг эхтэй харилцахад зарцуулж буй цагийг багасгасан юм.

Эх сурвалж: Supporting-teachers-back-school-efforts-toolkit-school-leaders. 2020. UNESCO

Бодлого боловсруулагчдад зориулсан “Сургууль эргэн нээх үед багш нарт туслах нь” гарын авлага, Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, ЮНЕСКО⁸

Энэхүү гарын авлагад “КОВИД-19” үед болоод дараа сургууль эргэн нээх үед

⁸ <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373479?fbclid=IwAR1AT--JAAOq5JrC9Oaf3ri3hhFhDf9yx-c47pf-pQfvhwMXLQjdPR1nagc> (сүүлд үзсэн 2020.10.17)

бодлого тодорхойлогч, боловсруулагч нар багш, ажилтнуудыг хэрхэн талаарх зөвлөмжийг багтаасан юм. Үүнд мөн адил дээр дурдсан 7 шалгуур үзүүлэлтээр анхаарах зүйлсийг жагсаан зөвлөжээ. Тухайлбал, багшийн эрх, үүргийг тодорхой болгох, ажиллах нөхцлийг дэмжих үүднээс сургуулийн удирдлага дараах шалгуурыг анхаарах ёстой талаар уг гарын авлагад ийн дурджээ.

...Сургуулийг хэзээ, хэрхэн, яаж буцаан нээхийг шийдэх, тодорхойлох нь тун ч төвөгтэй. Эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрдүүлэх, үүн дундаа хоорондын зай барих дэглэмийг мөрдүүлэх, түүнчлэн хүний нөөцийг бүрдүүлэх, хямралын үед ажлын хуваарийг тодорхойлох хэцүү. Боловсролын салбар аль хэдийнээ хэцүү байдалд орсон энэ үед эрх баригчид боловсролын салбарын зардлыг бууруулахдаа багш, ажилтнуудын эрхийг зөрчих, цалин хөлсийг бууруулах замыг сонгох эрсдэлтэй байна.

Боловсролын салбарын бодлого тодорхойлогчид дараах нөхцлийг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Хангалттай багшлах боловсон хүчинг бүрдүүлэх шаардлагатай. Хэрвээ багшийн нөөц хангалтгүй бол орлуулах цагийн багш, туслах ажилтанг хөлслөх, ингэхдээ холбогдох шалгуурыг тавих ёстой ;
- Багш, туслах ажилтнуудын цалин, урамшуулал, тэтгэмжийг сургууль хаасан, нээсэн бүхий л хугацаанд хугацаанд нь, бүтэн олгох замаар багш нарын эрх, статусыг хадгалах ёстой.;
- Уян хатан ажлын төлөвлөгөө, хичээлийн хуваарь бий болгох, нэг ангид суралцах хүүхдийн тоог тогтоох, өдөрт ажиллах цагийг тогтоох;
- Багш, туслах ажилтнууд, ялангуяа эмэгтэйчүүдэд гэр бүлдээ зарцуулах хангалттай цаг олгох зорилгоор уян хатан бодлого хэрэгжүүлэх.

Эх сурвалж: Supporting-teachers-back-school-efforts- Guidance for policy-makers. 2020. UNESCO

Үйлдвэрчний эвлэлийн туршлага

“КОВИД-19” эхэлснээс хойш боловсролын байгууллагын үйлдвэрчний эвлэлүүд “тасралтгүй суралцах эрх”-ийг хамгаалах, багш нарын ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг хамгаалах талаар ажилласаар байна. Эдгээр үйл ажиллагааг агуулгаар нь харвал:

Багш нарын ачааллыг бууруулах;

- Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах;
- Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангуулах;
- Зайны сургалтыг тасралтгүй, үр дүнтэй явуулах;
- Төр засгийн алдаатай шийдвэрийн эсрэг тэмцэх чиглэлд ажиллаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дэлхий нийтийг хамарсан "Ковид-19"-ийн нөлөө 1.6 тэрбум суралцагч, 63 сая багш нарт шууд сөргөөр нөлөөлсөн тоон мэдээ байна. Хичээл завсардах үеийн сургалтыг цахим, теле хичээлээр нөхөх оролдлого тулгарсан ч бодит байдалдаа суралцагч төдийгүй багш нар түүнд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр дутмаг байсан нь олон судалгаагаар илэрсэн юм. Тухайлбал, нийт суралцагчдын 50 орчим хувь нь, багш нарын олонх нь интернэт, түүнд холбогдох төхөөрөмж дутмаг, түүнчлэн бусдын адил хичээл завсардсан өөрсдийн хүүхдээ харж хандахын хажуугаар суралцагчдынхаа "тасралтгүй суралцах эрх"-ийг хангахын тулд хэн хэнээс илүү ачаалалтай ажиллаж байв

ЮНЕСКО-оос багш, хичээлийн эрхлэгч, боловсролын салбарын ажилтнуудыг хамгаалах, дэмжих, өнөөгийн тулгамдаад буй эрүүл мэндийн хямралтай тэмцэх хариу арга хэмжээнд тэдний оруулж буй хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрөхийг уриалж байгаа юм. Энэ дагуу "КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын хариу арга хэмжээ" боловсруулж, хэд хэдэн зөвлөмж гаргасны нэг нь "Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь" юм. Уг баримт бичигт онцолж буйгаар багш, боловсролын салбарын ажилтан нь үйлчилгээ үзүүлэгч байгаад зогсохгүй эрх эдлэгч бөгөөд боловсролын эерэг шинэчлэлийн хүчтэй нэг оролцогч учраас тэд "КОВИД-19" хямралын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөхөд оролцох ёстой. Түүнчлэн багшийн хэрэгцээ, чадавх, дутагдаж буй зүйлсийн талаар мэдээлэл цуглуулах нь чухал юм. Энэхүү "Багшлах, суралцах үйлд "Ковид-19" цар тахлын үзүүлсэн нөлөө" бичил судалгаа нь ч мөн дээрх зорилгын дагуу хийгдсэн юм.

"КОВИД-19"-ийн үеэр багшлах, суралцах үйлд дараах нөлөө илэрчээ. Үүнд:

Нэг. Оролцогчдын 90% орчим нь ажлын ачааллаа "өмнөхөөс ихэссэн" эсвэл "хэвээр" гэж хариулсан бол 77.3% нь "өмнөхөөс ихэссэн" гэж үзсэн юм. Бага, дунд сургууль тэр дундаа холимог өмчит бага, дунд сургуулийн багш нарын, түүнчлэн боловсролын шатлал, бүсээс үл хамаарч бүх эмэгтэй багш нарын ачаалал өмнөхөөс нэмэгджээ. (Тухайлбал, бага сургуулийн багш эмэгтэйчүүдийн 88%, дунд сургуулийн багш эмэгтэйчүүд 100% "ачаалал ихэссэн" гэж хариулсан юм.)

- Бага, дунд сургуулийн багш нарын дийлэнх нь эмэгтэй байх ба оролцогч эмэгтэйчүүдийн 76.1% нь өрх гэрийн ачааллаа хослуулах хүндрэлтэй байсан гэж хариулснаас "ачаалал ихэссэн" нэг шалтгааныг харж болно.
- Холимог өмчит сургуулийн багш нарын "ачаалал ихэссэн" гэх хувь

өндөр буй нь өмчийн онцлогоос шалтгаалсан давхар стандартаас шалтгаалсан байж болох талтай. Холимог өмчит сургуулийн багш нар нэгдсэн журмаар орж буй теле хичээлийн агуулгыг баталгаажуулсан хичээлээс гадна сургуулийн өөрийн хөтөлбөрийн дагуух хичээлийг цахимаар зааж байсан талаар судалгааны явцад дурдаж байв.

- Бүс нутаг алслагдах тусам боловсролын хяналт, шалгалт, тайлагналт сулардаг байх магадлал харагдаж байна. Зүүн, төвийн ба баруун бүсэд, нийслэлээс илүү ажлын ачаалал хэвийн гэсэн хариулт зонхилжээ.

Хоёр. Багш нарын хичээл төлөвлөж, бэлтгэн танхимаар заах гол үүрэг нь теле хичээлийг бататган цахим хичээл орох, даалгавар шалгах үүргээр солигдож, үүнд нэмэгдэн сурагчидтай холбогдох, эцэг эхчүүдтэй харилцах, удирдлагад ажлаа тайлагнах нь үндсэн ажил үүргийн нэг болжээ.

Гурав. Багш нарын 42% нь “цалин багассан” гэж хариулсан ба сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын багш нарын цалин буурч, мэргэжлийн болон дээд боловсролын багш нарын цалин хэвээр олгогджээ.

- Бага, дунд боловсролын багш нарын цалин анги, танхимаар хичээл заагдаагүйтэй холбоотойгоор илүү цагийн хөлс, анги даалт, үр дүнгийн урамшуулал олгогдоогүйгээс цалин багассан байх магадлалтай байна.
- Хувийн ба холимог өмчит сургуулийн багш нарын хувьд сургалтын хөтөлбөр төрийн өмчит сургуулийнхтай зөрдөгтэй холбоотойгоор цахим хичээл заасан ба цахим хичээлийн үр дүн тааруу байсан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, сурагчид сургалтын төлбөр төлөөгүйн улмаас байгууллагын орлого буурсан зэрэг үндэслэлээр цалин буурсан байх магадлалтай байна.

Дөрөв. Ажлын ачаалал, цалин хөлс хоорондоо урвуу хамааралтай байгаа нь нийт оролцогчдын 77.3% нь “ажлын ачаалал ихэссэн” гэх мөртлөө 42% нь “цалин багассан” гэж, “ажлын ачаалал ихэссэн” гэж хариулсан оролцогчдын 80.7% нь “цалин багассан” гэж хариулсан юм. Үндсэндээ зайн сургалтын үед багшийн аливаа нэмэгдэл цалинг олгоогүй нь зүй зохистой эсэх, энэ нь ачаалалтай хэр уялдаж буйг дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

Тав. Зайны сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад сургуулийн шатлал, байршил үл хамааран бүх багш нараас нэмэлт зардал гарчээ. Багш нар ажил үүргээ гүйцэтгэхийн тулд нэг удаад компьютер, ухаалаг утас, чихэвч, камер, микрофон, интернэт суурилуулах зэрэгт 100,000-2,000,000 төгрөг, утас, дата, цахилгааны төлбөрт сар бүр дунджаар 30-40 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд зөөврийн компьютер, ухаалаг утсыг лизингээр авсан нь анхаарал татаж байна. Зайн сургалтын үед оролцогчдын 18.5% нь ухаалаг утасгүй, 82.5% нь суурин компьютергүй, 14.4% хувь нь зөөврийн компьютергүй, 20.7% хувь нь гэртээ интернэтгүй байжээ.

Зургаа. Оролцогчдын тэн хагас нь гэрээс ажиллахад хүндрэлтэй байсан, нийт

дүнгээр 80% орчим нь “гэрээс ажиллахад байнга болон заримдаа хүндрэлтэй байсан” гэж хариулсан юм. Үүнд, эрэгтэйчүүдийн 32%, эмэгтэйчүүдийн 76.1% нь “гэрийн ажлаа багшлах ажилтай хослуулах хүндрэлтэй” байсан гэж хариулсан нь хүйсээс үүдэлтэй гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарьтай холбоотой байж болох юм.

Долоо. Зайны сургалтын үед шат, шатны удирдлагаас мэргэжлийн болоод бусад чиглэлээр дэмжлэг үзүүлэх тал дээр хангалтгүй байсан нь судалгаанаас харагдаж байна.

- Хөл хорио эхэлсэн 2020.02.01-ний өдрөөс хойш Боловсролын яамнаас багш нарт хандан явуулсан үйл ажиллагааны талаар оролцогчдын олонх “зохион байгуулаагүй, санахгүй байна, мэдэхгүй, дарамт мэдрүүлснээс өөр дорвитой ажил хийгээгүй” зэргээр сөрөг хандлагатай байв.
- Оролцогчдын 26% сургуулийн удирдлага, 33.5% дүүрэг, аймгийн Боловсролын газар, 23.6% нь Боловсролын яам тус тус “дэмжлэг огт үзүүлээгүй” хэмээн хариулжээ.
- “Дэмжлэг үзүүлсэн” гэх хариултыг харвал “чиглэл, удирдамжаар хангаж” буйг дэмжлэгт тооцсон нь харагдана. Оролцогчдын 68.3 хувь нь сургуулийн удирдлагаас, 38.3 хувь нь дүүрэг, аймгийн Боловсролын газраас, 38.7 хувь нь Боловсролын яамнаас “чиглэл, удирдамжаар ханган ажилласан” хэмээн дүгнэжээ.

Найм. Багш нарын ачааллын зонхилох хувь нь “цахим хичээл бэлдэх”-тэй холбоотой байсан ба аль ч шатны удирдлага байгууллагаас үүнтэй холбоотой буюу гарын авлага, сургалтын материал, арга зүйн сургалт, цахим хичээлийн талаар зааварчилгаа өгсөн гэх үзүүлэлт 20%-иас хэтрэхгүй байна.

Оролцогчдын 41.3% хувь нь өмнө бэлдсэн цахим зайны сургалтын материал ашиглаагүй, шинээр бэлтгэсэн гэсэн бол үлдэх нь өмнө бэлтгэсэн өөрийн, бусад багш нарын, Багшийн мэргэжил дээшлүүлэх институты, Хан академи, Зайны сургалтын үндэсний төвийн материал ашиглажээ.

Ес. Зайны сургалт эхлэх үед оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдал “хэвийн” байсан ба зөвхөн 14% нь сандрах, түгших, өөртөө итгэлгүй байх, айх, зугатмаар санагдах мэдрэмж “их эсхүл маш их” төрж байжээ. Ерөнхийдөө талаас илүү нь (57.3%) эдгээр сэтгэл зүйн байдал “огт мэдрэгдээгүй” гэж хариулжээ. Харин зайны сургалтын явцад оролцогчдын дунд ажлын ачаалал ихэссэнээс бухимдах (63.4%) болон багаар ажилладаг байдлаа санагалзах (50.8%) ганцаардах (21%), тусгаарлагдах (19%) мэдрэмж төрж байжээ. Энэ үр дүн оролцогчдын хүйс, сургуулийн байршил, өмчлөлөөс үл хамаарч ижил байлаа.

Арав. Зайны сургалтад багш нар бэлэн байгаагүй нь судалгаанаас харагдав. Оролцогчдын 73.3% өмнө нь зайны сургалтаар “хичээл зааж байгаагүй”, 75.2% нь зайны сургалтад хэрхэн хичээл заах талаарх “сургалтад хамрагдаж байгаагүй”, 20% нь цахим хэрэгсэлтэй, 2.8% нь цахим орчны программ хангалтай “ашиглаж

мэдэхгүй” зайны сургалт эхлүүлжээ. Зайны сургалтын төгсгөлд оролцогчид цахим орчинд ажиллах, цахим хичээл заахад шаардлагатай хэрэгсэлтэй ажиллах, харилцаа холбооны шинэ арга хэрэгсэлтэй ажиллах чадваруудад шинээр суралцсан тэр дундаа хичээл заах арга барилдаа өөрчлөлт оруулсан гэх үзүүлэлт өссөн байна.

- Эрэгтэйчүүдийн 60, эмэгтэйчүүдийн 76.3 хувь нь өмнө зайнаас хичээл зааж үзэж байгаагүй гэж хариулсан ба ерөнхийдөө эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол 10 орчим хувиар илүү “зайны сургалтад бэлэн байгаагүй” хэмээн хариулжээ.
- Дээд сургуулийн багш нар л бусдаасаа арай илүү өмнө нь зайнаас хичээл зааж үзсэн, ийм төрлийн сургалтад хамрагдаж байжээ. Харин бага, дунд сургуулийн багш нарын 70%-иас илүү нь өмнө зайнаас хичээл заах эсвэл ийм төрлийн сургалтад хамрагдаж байгаагүй ажээ.

Арван нэг. Багш нарт зайны сургалт явуулахаас илүү суралцагчидтайгаа холбогдох нь ихээхэн бэрхшээл дагуулж байжээ. Оролцогчдын 30% нь суралцагчидтайгаа өдөр бүр, мөн 30% орчим нь долоо хоногт нэгээс хоёр удаа, 9.5% нь сард нэгээс хоёр удаа холбогдсон бол 11.5% огт холбоо бариагүй байна. Суралцагчидтай холбогдсон давтамж нийслэлийн оролцогчдын хувьд өндөр байх агаад орон нутагт нийслэлээс харьцангуй бага буй нь алслагдмал байршил, малчин өрхийн хүүхэд зэрэг шалтгаантай холбоотой байж болох юм.

Арванхоёр. Зайны сургалтад суралцагчид ч мөн бэлэн байгаагүй нь судалгаанаас харагдаж байна. Суралцагчид “бие даан суралцах чадвар” сул байснаас гадна амьдралын боломж, нөхцлөөс шалтгаалан зайны сургалтад оролцох байдал хомс байжээ. Тухайлбал:

- Гэртээ зурагтгүй, сүлжээ ороогүй алслагдмал, олуулаа амьдардгаас хичээлийн цаг давхцаж буй тохиолдолд үзэх боломжгүй сурагчид олон байв.
- Гэртээ интернэтгүй, шинээр суурилуулах, дата төлбөр төлөх боломжгүй, эсхүл ухаалаг утас, хэрэгсэлгүй сурагчид олон байсан. Теле хичээл үзэх боломжтой байлаа ч түүнийгээ багшид шалгуулах, даалгавраа илгээх гэхээр интернэтгүй айл олон байв.
- Дунд, ахлах ангийн сурагчид гэрийн ажилд дарагдах, дүү нараа харах зэргээр хичээл хийх завгүй байв.
- Теле хичээлийн хурдыг гүйцэхгүй, ухраах-зогсоох-нөхөж үзэх боломжгүй сурагчид олон байв. Ер нь теле хичээлийн агуулга сурлагадаа сайн хүүхдэд зориулсан хурдтай байсан.
- Хэл, ярианы бэрхшээл, хоцрогдолтой, удаан ойлгоцтой, бие даан суралцах чадвар сул, хөгжлийн бэрхшээлтэй, малчин айлын хүүхэд олон байв.
- Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг сул, багштай хамтран ажилладаггүй, мөн цөм гадуур гарч ажилладаг учир хүүхэд харах

хүнгүй үлдэж байсан эсвэл гэр бүл салсан, өнчин, эцэг эх нь гадаадад амьдардаг, гадаад түгжигдсэн сурагчид цөөнгүй байв.

Арван гурав. Зайны сургалтын үед ялангуяа бага ангийн суралцагчдын хувьд эцэг эх, асран хамгаалагчдын тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай ба багш нарын зүгээс үүнд сэтгэл хангалуун бус байна.

- Багш нарын 58% орчим нь эцэг эхчүүдийн оролцоонд сэтгэл хангалуун бус байжээ. Энэ үр дүн нь хүүхдийг сургах ачаалал багшийн нуруун дээр хэвээр л байсныг илтгэх ба нөгөө талдаа зайны сургалтын чанарт нөлөөлөхүйц хэмжээнд байгааг анхаарууштай.

Арван дөрөв. Зайны сургалтын үед урьд өмнөхөөс илүү багш, эцэг эхийн харилцах давтамж ихэссэн ба үүний үр дүнд багш нарын 55.7% нь эцэг эх, асран хамгаалагчтай харилцах харилцаанд ямар нэг “өөрчлөлт ороогүй” гэсэн бол “эерэгээр өөрчлөгдсөн” хэмээн 35.9% нь, таагүй харилцаатай болсон хэмээн 8.3% нь үзжээ.

- Эерэг өөрчлөлтийн шалтгаан: Эцэг эх, асран хамгаалагчидтай олон дахин холбогдох, гэрээр очиж уулзан, дасгал, даалгавар өгөх зэрэгт эцэг эх, асран хамгаалагчид таатай хандаж байв. Мөн багшийн ачааллыг ойлгох, өмнөхөөс илүү багштай харилцах болсон зэрэг нь багш-эцэг эх, асран хамгаалагчдын харилцаанд нааштай нөлөөлжээ.
- Сөрөг өөрчлөлтийн шалтгаан: Эцэг эх, асран хамгаалагчидтай олон дахин холбогдох, гэрийн даалгавар нэхэх зэрэгт тэд дургүйцжээ. Түүнчлэн сургуулийн төлбөр нэхэх, хичээлийн ачаалал зэрэг багшаас үл хамаарах олон нөхцөлд багшийг буруутгах хандлага мөн илэрч байв.

Арван тав. Хүүхдэдээ цаг зарцуулах, цахим орчинд ажиллах, техник технологийн чадвар эцэг эх, асран хамгаалагчдад хангалтгүй байсан хэмээн багш нарын 80-90% хувь нь үзсэн юм. Үүн дундаа бага, дунд ангийн болоод баруун бүсгийн аймгууд болоод нийслэлийн хамгийн хүн амын төвлөрөл өндөр дүүргүүд болох Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн багш нар эцэг эх, асран хамгаалагчдын оролцоонд сэтгэл дундуур байна.

Арван зургаа. Зайны сургалтын үед буюу ер нь хөл хорионы үед суралцагчдад хоол тэжээлийн хангалттай байсан эсэх, аливаа хүчирхийллээс ангид байсан эсэх талаар багш нарын 40% нь “хангалтгүй” дүн тавьсан бол 46% нь “сайн байсан” гэжээ.

Арван долоо. Оролцогчид бүхэлдээ зайны сургалтыг тийм ч “үр дүнтэй байсангүй” хэмээн үнэлсэн ба “халдвар хамгааллын дэглэмээ сайн сахиж танхимын сургалт хийх” хүсэлтэй буйгаа дурдсан юм. Түүнчлэн хөдөө орон нутагт утас, интернэтийн сүлжээ болоод тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдлыг харгалзсан бодлого хэрэгжүүлэхийг удаа дараа хэлж байв. Зайлшгүй зайнаас хичээллэх болвол шаардлагатай зүйлсийг оролцогчдын хариулсан давтамжаар жагсаан харуулбал:

- Цахим хичээлийн нэгдсэн платформ бий болгох;
- Цахим сургалтын арга зүй, нэгдсэн зөвлөмжөөр хангах;
- Урьдчилан бэлтгэсэн цахим хичээл, даалгаврын сан бүрдүүлэх;
- Цахим хичээл бэлдэх сургалтад хамруулах (агуулга, арга зүйгээс гадна тоног төхөөрөмж, программ ашиглах талаар) ;
- Суралцагчийг зайнаас үнэлэх үнэлгээний шинэ арга зүй боловсруулах;
- Багш нарыг үнэлэх арга зүй боловсруулах, (цахим хичээлийг ердийн хичээлтэй адилтгах эсэх талаар);
- Сургууль, дүүрэг аймгийн боловсролын газар, Боловсролын яам нэгдсэн арга зүйгээр, маш тодорхой удирдах (гэнэтийн шийдвэр гаргахгүй байх, багш нараас шаарддаг тайлан, бичиг цаасыг багасгах) ;
- Техник хэрэгсэл (зөөврийн компьютер, камер, камерийн хөл, гэрт байршуулах самбар, бичгийн цаас);
- Багш төдийгүй оюутан, суралцагчдад интернэт, дата, утасны төлбөр олгох, гэр хороолол, хөдөө орон нутагт интернэтийн сүлжээтэй болгох;
- Суралцагчдын гэрээр очиж ажиллах үед унаагаар хангах;
- Эцэг эхийн дэмжлэг хэрэгтэй тул зөвхөн багш нарт гэлтгүй эцэг эхчүүдэд зориулсан зайны сургалтын гарын авлага боловсруулах;
- Эцэг эхчүүдтэй шинэчилсэн журмаар буюу зайны сургалтын үеийн нөхцлөөр гэрээ байгуулах;
- Цалин хөлс нэмэх, ажлын ачаалал буурахгүй байгаа тул илүү цагийн зэрэг нэмэгдэл хөлсийг хасахгүй байх;.
- Багш нарт гэрээсээ гэлтгүй сургуулиасаа ажиллах боломж олгох.

Үндсэндээ энэхүү судалгааны үр дүнд зайны сургалтын үеэр:

- Багшийн ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын орчин нөхцлийг тооцон ачааллыг бууруулах арга хэмжээ авах;
- Багшийн цалин хөлсийг бууруулахгүй байх, боломжтой бол нэмэгдүүлэх;
- Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдхүүн, гарын авлага, материалаар хангах;
- Зайн сургалт явуулах талаар арга зүйн дэмжлэг үзүүлэх; зайны сургалтыг хэрэгцээний судалгаанд тулгуурлан зохион байгуулах
- Сэтгэцийн эрүүл мэндийг анхаарах, зөвлөмж, удирдамж өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;
- Суралцагчдын суралцах нөхцөл, боломжийг дээшлүүлэх, эрх тэгш байдлыг хангахад анхаарах шаардлагатай нь харагдлаа.

САНАЛ (буюу дахин хөл хорионы шалтгаант зайны сургалтын үед анхаарах зүйлс)

”КОВИД-19” цар тахлын аюул буураагүй, урьдчилан сэргийлэх вакцин гараагүй энэ үед дахин хөл хорио тогтоох, сургуулийг хаах, зайнаас хичээллэх магадлал байсаар байна. Иймд 2019-2020 оны хичээлийн жилийн тэн хагаст үргэлжилсэн зайны сургалтын чанар, багш суралцагчдынтухайн үеийн нөхцөл байдлыг

тогтолцооны хүрээнд үнэлэх, түүндээ тулгуурласан төлөвлөгөө гаргах нь чухал.

Юун түрүүнд багш нарыг зөвхөн гүйцэтгэгч, зайны сургалтыг хэрэгжүүлэгч гэж үзэхээс гадна нэг талаар цаашдын төлөвлөгөө гаргахад оролцогч, үнэтэй хувь нэмэр оруулагч, нөгөө талаар тэд ч бас хөл хорионд орсон бусад иргэдийн адил нөхцөлд буй гэдгийг анхаарч үзэх шаардлагатай юм. Иймд:

Нэг. Зайны сургалтын үед багш нарт тулгарч буй бэрхшээл, зайны сургалтыг амжилттай хэрэгжүүлэх, багшийн нөхцөл байдлыг сайжруулахад шаардлагатай зүйлсийг тодруулахуйц өргөн хүрээний, хөндлөнгийн судалгаа шаардлагатай байна. Үүнд:

- Зайны сургалтын үеэрх багшийн ажлын ачааллыг судлан гаргах, түүнд тулгуурлан ачааллыг бууруулах төлөвлөгөө гаргах;
- Зайны сургалтад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, сургууль, төрөөс хангахад анхаарах.
- Багшийг зайны сургалтын арга зүйд сургах, хэдийгээр хөл хорионы үеийн хичээлийн хоцрогдол арилгахаар завгүй ажиллаж буй энэ нөхцөлд ч хичээлийн хуваарь, ачааллыг зохистойгоор төлөвлөж, багш нарыг дараагийн хөл хорионы үед ажил үүргээ зохист хэмжээнд гүйцэтгэхэд бэлдэх;
- Зайны сургалтад шаардлагатай багшид зориулсан гарын авлага, цахим материалын тоог нэмэх, мэдээллийг боломжит олон хувилбараар хүргэх;
- Багшийн ачааллыг зохистой түвшинд байлгахын тулд бүх талын оролцоо, дэмжлэг үзүүлэх. Тухайлбал, нэн шаардлагатай бус үнэлгээ, шалгалт, тайлан, мэдээ, уралдаан, тэмцээн зэргийг хойш тавих;
- Багшаас гарч буй нэмэлт зардлыг (тухайлбал, утас, интернетийн төлбөр, суралцагчдын гэрээр явахад зарцуулж буй унааны зардал) бууруулах талаар дэмжлэг үзүүлэх.
- Багшийн ажлын үр дүн зөвхөн багшаас хамаарахгүй суралцагч талаас ихээхэн хувь нь шалтгаалах тул суралцагчдыг ч анхаарч, тэдний онцлогт тулгуурласан зайны сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Эцэг эхчүүдэд гэрээр хичээллэх үед хүүхэддээ үзүүлэх дэмжлэгийн талаар зааварчилгаа удирдамж боловсруулж өгөх,
- Эцэг эхчүүдэд хүүхэддээ бие даан суралцах чадварыг эзэмшүүлэх арга зүйг сургах гаардлага байна.
- Эцэг эхчүүдэд хүмүүжлийн эерэг арга хэрэглэх, хүүхдээ цахим эрсдлээс хамгаалах, идэвхтэй хөдөлгөөн хийлгэх, харилцааны ур чадваруудыг хөгжүүлэх агуулгуудыг боловсруулж хүргэх
- Хамгийн гол нь бүх шатны удирдлагын зүгээс тодорхой, ойлгомжтой, урьдчилан төлөвлөж болохуйц удирдлагаар хангах шаардлагатай байна. Тухайлбал, бүх шатны удирдлагын уялдааг сайжруулж, давхардсан үүрэг даалгаврын тоог багасгах зэрэг.

“БОЛОВСРОЛ: ЧАНАР, САНХҮҮЖИЛТ, ХАРИУЦЛАГА” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ Х ЧУУЛГАНЫ БАЙР СУУРИЙН БАРИМТ БИЧИГ

“КОВИД 19 ба БОЛОВСРОЛ”

2020 оны 12 сарын 9-ний өдөр

ҮНДЭСЛЭЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагууд хамтран гүйцэтгэсэн “Ковид-19 халдварын боловсролд үзүүлж буй нөлөө” сэдэвт “тэгш хамруулах боловсрол”, “хүүхэд хамгаалал”, “төсөв санхүүжилт”, “нийгмийн эгэх хариуцлага” гэсэн 4 хүрээний сэдэвчилсэн мониторингийн¹ үр дүнд үндэслэн энэхүү байр суурийн баримт бичгийг боловсрууллаа. Мөн түүнчлэн эвслийн гишүүн байгууллагууд болох Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран хийсэн “КОВИД – 19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ?” Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа, Монголын Боловсрол, Шинжлэх Ухааны Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой хамтран гүйцэтгэсэн “Багшлах, суралцах үйлд “КОВИД 19-ийн үзүүлсэн нөлөө” судалгааны үр дүн болон бусад байгууллагаас Х чуулганд танилцуулсан судалгаа, дүн шинжилгээний тайлан, хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос гаргасан санал зөвлөмжид тулгуурлан боловсруулсан болно.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 03 дугаар сарын 12-оос Коронавирусын халдварыг цар тахал гэж зарласан бөгөөд манай улс 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын онцгой комиссын хурлаар 12 сарын сүүлээр улирлын амралт, үргэлжлээд томуугийн дэгдэлтийг таслан зогсоох зорилгоор түр завсарлаад байсан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 1 сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2 өдөр хүртэл түр зогсоох, энэ хугацаанд сургалтын агуулга хөтөлбөрийг теле болон цахим аргаар хүргэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдад үүрэг болгожээ. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийг болон бусад шатны боловсролын байгууллагыг түр хаах хугацааг дахин 3 удаа сунгаж, 9 дүгээр сарын 1-нээс хичээл орж эхлэх шийдвэр гаргаснаар Монгол Улсын хэмжээнд СӨБ-д 263,333 сурагч, ЕБС-д 640,499 сурагч, насан туршийн боловсролын 6,917 сурагч, их дээд сургуульд 148,446 оюутан сурагчид теле болон цахимаар хичээл үзэх шаардлагатай болсон юм.

Тиймээс эрх тэгш, тэгш хамруулсан чанартай боловсролыг хүн бүрт олгохын төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагын гишүүд, дэмжигчид бид хүүхэд залуус, насанд хүрэгчдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд анхаарал

1 2020 оны 7 сарын 31-ны байдлаар

хандуулж, энэхүү байр суурийн баримт бичгийг Монгол улсын Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандан боловсруулав.

ТЕЛЕ БОЛОН ЦАХИМ СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Салбарын яам болон бусад байгууллагуудын хийсэн судалгааны үр дүнгээс харахад боловсролын бүх шат, түвшинд суралцагчдын дунджаар 20 гаруй хувь нь зайны сургалтад хамрагдаагүй дүр зурагтай байна.

Нөлөөлөх хүчин зүйл 1. Цахилгаан эрчим хүчний хүрэлцээ болон Холбоо харилцааны дэд бүтцийн хангамж, найдвартай байдал

Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээгээр манай улс дэлхийн дунджаас 11.5 хувь доогуур байна.² Монгол улсын 330 сумын 319 нь дотоодын төвлөрсөн эрчим хүчний системүүдэд цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон, 1 сум сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр цахилгаан эрчим хүчээ хангаж байна.³ Мөн 4,817 өрх цахилгаан эрчим хүчний эх үүсвэргүй байна⁴. Нийт малчин өрхийн тоо 171.6 мянга бөгөөд тэдний 82,6% цахилгааны үүсгүүртэй байгаагийн (92,3% нь нарны, 0,3% нь салхины, 7,4% бага оврын мотор, аккумулятор) байгаа ба нийт өрхийн 73,1% телевизортой байна⁵.

2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 897,427 өрх бүртгэлтэй бөгөөд дунджаар 317,317 өрх буюу 35,3% нь интернэтэд холбогдсон байдаг боловч орон нутагт 72,789 өрх буюу 0.08% л интернэтэд холбогдсон үзүүлэлттэй байгаа юм.

Үндэсний статистикийн хорооны судалгаагаар Улаанбаатар хотод 2018 оны байдлаар 387,453 өрх байгаагийн 185,234 буюу 47.9% нь гэртээ компьютергүй байна. Зөвхөн Улаанбаатар хотод амьдардаг гэртээ компьютертой 202,219 өрхийн 165,336 буюу 81.7% нь интернэтэд холбогдсон байдаг байна.

Бүх шатны боловсрол сургалтын үйл ажиллагаа теле болон цахим хэлбэрт шилжсэн өнөөгийн нөхцөл байдалд гэртээ компьютергүй өрх, компьютертэй ч интернэтгүй өрхийн хүүхдүүд цахим хичээлд оролцох боломж хязгаарлагдмал байгаа ба гэртээ телевизоргүй, байсан ч кабельгүй, кабельтай ч ухрааж үзэх үйлчилгээгүй өрхийн хүүхдүүд зайны сургалт, хичээлээс хоцрох эрсдэлд оржээ.

Нөлөөлөх хүчин зүйл 2. Уламжлалт мал ахуйн соёл, жендэрийн тогтсон үүрэг, амьдралын хэв маяг, амьжиргаа зэрэг нийгмийн хүчин зүйлс

Хичээл хаагдах үед хөдөөд мал төллөж таарсан, нөгөөтэйгүүр цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэн зэрэг нь малчин өрхийн хүүхдүүдийн теле болон цахим хичээлд хамрагдахад хүндрэл бэрхшээл учруулжээ.

2 Монгол Улсын Эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ, УСХ, 2019

3 Эрчим хүчний яам, 2017

4 ХАОСТ, 2020, УСХ

5 Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2019, УСХ

Нөлөөлөх хүчин зүйл 3. Малчдын хүүхдүүд ба үндэстний цөөнх хүүхдүүдийн сурч боловсрох тэгш хүртээмжийг хангах асуудлыг орон нутагт хариуцуулан орхисон нь бодлогын хийдэл үүсгэсэн.

Нөлөөлөх хүчин зүйл 4. Салбарын яамны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах бодлогын чиглэлийг тууштай барьж, чухал шийдвэрүүдийг гаргаж ирсэн нь сайшаалтай байгаа ч цахим болон теле хичээл явагдах үед тэдэнд нэн шаардлагатай тусгайлсан дэмжлэг, тохирох хэрэглэгдхүүнээр хангах зохион байгуулалтыг хийж чадсангүй.

Нөлөөлөх хүчин зүйл 5. Ковид 19-ын дам нөлөөнд хамгийн их нэрвэгдсэн бүлэг болох амьжиргааны түвшин доогуур өрхийн нийгэм-эдийн засгийн статус доогуур хүүхдүүдийн боловсролын асуудал бүрэн орхигдсон байна.

Нөлөөлөх хүчин зүйл 6. Хүүхэд, залуусын хувьд хязгаарлагдмал орчинд гэртээ удаан хугацаагаар байж, найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ харилцаж чадахгүй болсноор уйтгарлаж, сэтгэл санаа нь тогтворгүй болж, ганцаардсан байна. Ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн хувьд хамгийн их тулгамдсан асуудал нь нийгэмшлийн буюу сэтгэл санааны хямрал, ганцаардлын асуудлууд байв.

Нөлөөлөх хүчин зүйл 7. Зайны сургалтын үед гэр бүлийн дэмжлэг, оролцооны ялгаатай байдлыг нөхөх, багшийн цахим болон бусад багшлах ур чадварын ялгаатай байдлыг арилгах, сурагчид, эцэг эхчүүдийн нийгэм-сэтгэл зүйд үзүүлж буй нөлөөг бууруулах, ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн харилцаа-нийгэмшлийн эрэлт хэрэгцээг хангах зэрэг бусад бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээгүй нь суралцагчдын хамрагдалт, гүйцэтгэл, сурлагын амжилтад нөлөөлж, тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхэд хүргэсэн байна.

Нөлөөлөх хүчин зүйл 8. Сургууль, цэцэрлэг хаасан нь багш, эцэг эх, сурагч нэг түвшинд хамтран ажиллах шаардлага тулгарч, хичээл хийх, амжилттай суралцах, шалгалт өгөх, төгсөх зэрэг асуудалд нэгэн зэрэг санаа зовсон, өдөр тутамд өөр хоорондоо харилцаа холбоо барихад хүргэсэн бөгөөд бүх талууд хангалттай дэмжлэггүй, шаардлагатай нөөцгүй, бэлтгэлгүй, бүгд туршиж үзэж байгаа, байнгын хяналт, шалгалтгүй суралцах, багшлах буюу бүгд бие даасан байдалтай боловсрол сургалтын үйл ажиллагааг үргэлжлүүлсэн гэж үзэж байна. Гэтэл боловсролын салбарт ажилладаг талуудад төдийгүй бусад оролцогч талуудад хандсан зөвлөмж, чиглэл, дэмжлэг, үйл ажиллагаа дутмаг байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Нөлөөлөх хүчин зүйл 9. Теле ба цахим хичээлд хамрагдалтын байдалд тавих хяналт орон нутгаар ялгаатай, яамны түвшинд хичээл, сургалтын үйл ажиллагааны талаар тоон мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээ хийх байдал сул байна.

БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2020 оны 04 сарын 29 өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсанаар боловсролын сайдын төсвийн багцаас өөр сайдын багц руу (нийгмийн халамжийн зардалд) шилжүүлэн зарах эрх зүйн үндэслэл тавигдсан нь боловсролын салбарын санхүүжилтийн өнөөгийн ба ирээдүйн байдалд эрсдэл авчирчээ.

Боловсролын төсөв санхүүжилтийн талаар, хэмнэгдсэн төсөв, ялангуяа теле болон цахим хичээлийн санхүүжилтийн талаарх мэдээллийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд гаргаж өгөхдөө хойрго байгаа нь Төсвийн тухай хуулийн зарчимд нийцэхгүй байна.

Багш нарын зайнаас ажиллах үеийн ажлын ачааллыг тооцолгүй, ажлын үнэлгээний аргачлалдаа өөрчлөлт оруулж уян хатан хандалгүй цалин хөлсний зардлаас ихээхэн хэмнэлт гаргасан байгаа нь багш дутагдах явдлыг улам даамжруулах эрсдэлтэйг анхаарч үзэх шаардлагатай.

Мэдээлэл-харилцааны технологийн хувийн компаниуд дижитал сургалтын модуль болон платформуудыг идэвхтэйгээр сурталчилж, боловсролын салбарт хүч түрэн орж ирж өрсөлдөж, боловсролын технологийг ашгийн төлөө хөгжүүлэх явдлыг улам хурдасгах, боловсролын үндсэн үйл ажиллагааны төсөв хөрөнгийг хуваалцах эрсдэлтэй байна.

Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн хувьсах зардлын санхүүжилтийг зогсоосон асуудал хамгийн их маргаан тэмцэл дагуулж, Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны шуурхай утас, цахим шууданд хэрэглэгчдээс ирсэн нийт гомдлын 80 хувийг их, дээд сургууль болон төрийн бус өмчийн ЕБС-ийн сургалтын төлбөр төлөхтэй холбоотой гомдол эзэлжээ.

НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН ТАЛААР

Манай улсын хувьд дээр дурдсанчлан, зайн сургалтыг 2000 оны эхэн үеэс хөгжүүлж, 2002 оноос “Зайн сургалтын үндэсний хөтөлбөр”, 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”, 2012-2016 оны хооронд “Нэг Монгол санаачилга” зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байсан боловч нийтээр зайны сургалтад шилжих шийдвэр гарах үед орчин үеийн түвшинд суралцагчдын эрэлт хэрэгцээг хангахуйц хууль эрх зүйн орчныг ч, хэрэгжүүлэх системийг ч цогцоор нь бий болгож хараахан чадаагүй, бүх шатны боловсролын байгууллагууд 100 хувь зайн сургалтад шилжин ажиллахад бэлэн бус байсан гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Боловсролын бүх шат түвшинд сургалтын үйл ажиллагаа жигд явагдсан гэсэн хангалттай нотолгоо олдсонгүй. Их дээд сургуулиуд, коллеж, төрийн бус өмчийн

бүх шатны боловсрол сургалтын байгууллагууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг хамарсан тушаал шийдвэр, зөвлөмж гарсан эсэх, зохих дэмжлэгийг үзүүлж чадсан эсэх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд бүрэн хяналт тавьж чадсан эсэх, шаардлагатай дата мэдээллийг цуглуулж чадсан эсэх нь эргэлзээтэй байна. Боловсролын салбарт зайны сургалтын талаар хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ямар нэг тайлан цахим хуудсанд байхгүй байна.

Цахим болон теле сургалтын чанар, хүртээмжийг шаардсан ИНБ-уудын хүсэлт, шаардлага цөөнгүй гарсан боловч тэдгээр талуудын өгсөн мэдээллээс харахад төрийн хариу үйлдэл буюу, асуудлыг шийдвэрлэхээр авсан арга хэмжээ хангалтгүй байсан гэж дүгнэж болохоор байна. Энэ нь боловсролын үйлчилгээг хүртэгч талууд нэг талаар тогтолцооны асуудлыг хөндөж, урт хугацаанд хөрөнгө мөнгө дайчилж шийдэхээр асуудлууд гаргаж тавьсан байтал боловсролын салбарын хэмнэгдсэн төсвийг өөр салбар руу татсантай холбоотой байх магадлал байна.

Боловсролын кластер, Боловсролын салбарын зөвлөлдөх бүлэг (LEG) зэрэг боловсролын оролцогч талуудтай зөвлөлдөх механизмууд зохих ёсоор ажиллаж, БСШУСЯ-наас цахим хуудсандаа үйл ажиллагааны тайлан мэдээллийг 1-7 сарын хугацаанд тавьж, Ковид-19 халдварын үеэр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тайлагнаж, олон нийтэд нээлттэй ажилласан байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын үед улс, орнуудын боловсролын салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг хайх, орчуулах, цахим хуудаст байрлуулах ажлыг зохион байгуулсан ба тус яаманд хандан иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах 1800-1209 дугаарын утас, 1209@mecs.gov.mn и-мэйл хаягийг шинээр байгуулан ажиллуулсан нь сайшаалтай.

ТЭГШ ХАМРУУЛСАН БАЙДАЛ

Боловсролын яамнаас 2020 оны 2-5 дугаар саруудын дунджаар гаргасан СӨБ-ын ба бага, дунд боловсролын суралцагчдын теле хичээлийн хамрагдалт харахад улсын дундаж 74.7%, аймгийн дундаж 75%, сумын дундаж 69,5%-ийн ирцтэй байсан байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд

БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын телевизүүдийн холбоотой хамтран бага, дунд боловсролын хувьд шат түвшинд “теле хичээл”-ийг зохион байгуулж, бүх хичээлийг дохионы орчуулгатайгаар, Баян-өлгий аймагт үндэсний цөөнхийн казах, тува хэлээр, насанд хүрэгчдэд зориулсан насан туршийн боловсролын хичээлүүдийг болон дүйцсэн хөтөлбөрийн хичээлүүдийг хүргэсэн. Мөн тусгай хэрэгцээт боловсролын теле хичээлийг (тусгай сургуулийн сурагчдад) I-IX ангийн монгол хэл, математик, нийгэм ахуйн баримжаа хичээлүүдээр зохион байгуулсан. БШУЯ-наас мэдээлснээр 640,499 сурагч ЕБС-д суралцдаг бөгөөд теле хичээлийн хамрагдалт

86-90% байна гэж үзсэн.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед явагдаж байгаа теле хичээлийн чанарыг сайжруулах талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, боловсролд тэгш хамран сургахад тулгамдаж байгаа бусад асуудлын талаар тандан судалгаа явуулж, теле хичээлийн бэлтгэл, чанар, үр дүнг сайжруулах, хүүхэд эцэг эхчүүдийг зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, зардлыг шийдвэрлэн ажилласан байна.

Сургуулийн өмнөх боловсрол

2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн сургуулийн өмнөх боловсролын теле хичээлийг бэлтгэн хүргэсэн байна. Монгол Улсын хэмжээнд СӨБ-д 263,333 хүүхэд хамрагддаг бөгөөд яамны өгсөн мэдээллээр хүүхдүүдийн хамрагдалт 89.1% байсан гэж үзжээ. Теле хичээлтэй холбоотой асуудлаар аймаг, нийслэлийн Боловсролын газруудад 2 удаа зөвлөмжийг яам болон хүрээлэнгээс хүргүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага бүр өөрсдийн дотоод нөөцдөө тулгуурлан цахим хичээл, хэрэглэгдэхүүн байршуулах групп нээж байршуулан суралцагчдад хүргэн ажилласан ба Moodle, google classroom, Powerpoint, Adobe flash, Google Docs, гэх мэт цөөнгүй програм болон компьютер, бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл, гар утас ашиглан цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэсэн боловч дийлэнх нь Powerpoint ашиглан хийсэн цахим хэрэглэгдэхүүн байгаа ба видео бичлэг, цахим тест зэрэг нь цөөн тоотой ашиглагдсан байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс авсан судалгаанд 80 сургууль оролцсоны 43 сургууль буюу 53,7% нь цахим хичээл явуулжээ. Энэхүү цахим хичээл явуулсан сургуулиудын хичээлд хамрагдалт 53.9%-77.3%-тай байсан байна.

Их, дээд сургуулиуд

Монголын Оюутны Холбооны зүгээс 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 1а/013 тоот албан бичгээр БСШУСЯ-нд шаардлага хүргүүлэхдээ цахим сургалтанд шаардлагатай техник хангамж, интернет сүлжээгүй, хурд удаан, багтаамжгүй, давтан үзэх боломжгүй зэргээр цахим сургалт нь хүртээмжгүй байсан бөгөөд сургалтын арга зүй, стандарт, агуулга тохиромжгүйгээс үүдэн чанаргүй; уян хатан бус, амьдралын бололцоо, боломжийг харгалзахгүй байх, орон нутаг, алслагдсан байдлыг тооцохгүй цаг хугацаагаар шахах зэргээр цаг үетэй зохицоогүй; оюутан бүрд цахим сургалтын гарын авлага, ном, товхимол, техник хэрэгсэл байхгүй учраас хүрэлцээгүй байна гэж үзсэн байна.

НИЙГМИЙН ЯЛГААТАЙ БҮЛГҮҮДИЙН ХУВЬД

ННФ ТББ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран судалгаа хийж үзэхэд ТВ хичээлийн чанар, хүртээмж муу байгаа тул “боловсролын асуудал орхигдож байна”, “маш хүнд асуудал болж байна”, “сурлагын хоцрогдол үүсэж байна” гэж оролцогчид онцолжээ. ТВ хичээл зааж байгаа багшийн хурдыг гүйцэхгүй тул ойлгохгүй байгаа, сургууль, багш нь хүүхэд, эцэг эхтэй холбоо тасалдаж, эцэг эх нь санаачилга гаргахгүй бол ангийн багш асууж сурагладаггүй байдал нийтлэг байгаа болон хүүхэд хөгжүүлэх хичээлийн бус цагийн нэмэлт сургалт, заслын үйлчилгээ бүгд зогссон нь хүүхдийн ерөнхий хөгжилд сөргөөр нөлөөлөх вий гэсэн зовнил эцэг эхчүүдийн дунд өсжээ.

2020 оны 05 дугаар сард малчин өрхийн хүүхдүүд хичээлээ үзэж чадаж байгаа эсэх талаар цахим асуулга авч, сошиал медиа анализ хийж үзэхэд нийт 186 хүн сэтгэгдлээ үлдээсний 67.2% нь ТВ огт үзэж чадахгүй байгаа, 7% нь үзэх боломжгүй байгаа, 6% аргалаад үзэж байгаа, 19.3% нь бусад байдлаар хариулжээ. Гол шалтгаан нь техник технологийн байдал, хүртээмж, байгаль, цаг уурын байдал, ахуй амьдралын нөхцөл, төрөөс гарсан шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой гэж хариулжээ.

Зайны сургалт нь сургалтын үйл ажиллагааны чанар, гүйцэтгэл, эрх тэгш байдалд сорилт авчирч, өмнө байсан боловсролын тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх эрсдэлтэй байна. Хамрагдалтын ялгаатай байдлаас гадна дараах хүчин зүйлүүд суралцагчдын гүйцэтгэл, сурлагын амжилтад нөлөөлж байгаа нь эрсдлийг улам нэмэгдүүлж, тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Гэр бүлийн дэмжлэгийн ялгаатай байдал: нийгэм-эдийн засгийн статустай холбоотой эцэг эхийн оролцооны ялгаатай байдлаас улбаатай
- Багшийн дасан зохицох чадвар, багшлах ур чадвар, цахим ур чадварын ялгаатай байдал
- Сурагчид, эцэг эхчүүдийн нийгэм-сэтгэл зүйд үзүүлж буй нөлөө
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хувьд туслах багш, дэмжлэгийн орчингүй суралцах

Хүүхдийн суралцах, хөгжих үйл явц харилцаанд суурилдаг тул теле хичээл нь нэг талын урсгалтай мэдээлэл өгч сургалтын үр дүн тааруу байх нөхцөл бүрдэж байна. Анги дэвших шалгалт цуцлагдаж, сургалтын агуулгыг бүрэн эзэмшээгүй нь дараагийн ангид дэвшин сурахад нөлөөлөх эсэх, ер нь эдгээр хүүхдүүдийн дараагийн шатны боловсролын байдал, ажил, амьдралд ямар түвшинд нөлөөлөх вэ гэдэгт эцэг эхчүүд санаа зовж байна.

Сургууль эргэж нээгдэхэд теле болон бусад хэлбэрээр огт хамрагдаагүй, эсвэл бүрэн хамрагдаагүй хүүхдийг ялгаварлах, дарамтлах, сургууль завсардахад

хүргэх, ариун цэврийн шаардлага биелүүлж чадаагүйгээс хичээлд ирэхгүй болох зэрэг эрсдлүүд байна гэж харж байна.

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Сургууль цэцэрлэгийг түр хааснаас үүдэн хүүхэд гэртээ хараа хяналтгүй үлдэх, хүүхэд асрах, харах үйлчилгээгүй олдоцгүй болох, гэртээ боловсролын үйлчилгээнд хамрагдах үед туслах, хяналт тавих байдлалд хангалтгүй байх, гэр бүлийн таагүй орчинд олон цагаар байх, хоол хүнсний үйлчилгээнээс тасрах зэрэг олон асуудлууд зэрэгцэн үүссэн юм. Мөн урт хугацаагаар хилийн хориг тавих, орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарлах, зарим үйлчилгээний газруудыг хаах зэрэг арга хэмжээ авснаас үүдэн иргэдийн орлого буурах, сэтгэл зүйн хямралд өртөх, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, архи дан согтуурах явдал нэмэгдэх зэрэг хүүхдийн эрх хамгаалалд сөрөг үр дагаврууд гарсан.

Мөн гадагшаа гарах хөдөлгөөнийг хязгаарласны улмаас зай талбай багатай гэртээ бүгэж, нийгэмших, үе тэнгийхэнтэйгээ харилцаж чадахгүй болсноор сэтгэл зүйн дарамт, айдас мэдэрч, тэдний нийгэм-сэтгэл зүйн хувьд анхаарах шаардлагатай нөхцөл байдал үүссэн. Эцэг эхчүүд хүүхдүүдийг гэрээсээ гарахгүй байхаар нийгмээс тусгаарлагдан, сурч хөгжих нь хязгаарлагдмал болж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлсэн.

15-18 насны судалгаанд оролцсон залуусын хувьд найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ уулзаж чадахгүй байгаа нь стресс, сэтгэл гутрал цаашлаад бусадтай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж байгаагаа илэрхийлсэн бөгөөд сургууль хаагдах нь ялгаатай бүлгийн хүүхдүүдийн хувьд адил бус үр дагавар авчирч байгааг илрүүлсэн. Охид гэртээ ихэнх цагийг өнгөрөөж байгаа тул гэрийн ажил олон цагаар хийх болжээ. Ялангуяа малчин айлын охид өмнө нь дотуур байранд амьдарч хичээлээ хийдэг байсан бол, гэрээсээ хичээллэх үед дүү нарынхаа хичээлийг хийлгэх, хонь хариулах, гэр орноо цэвэрлэх гээд ачаалал нэмэгдсэн байна. Өсвөр насны хүүхэд, залуус өөрсдийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа, дугуйлан, клубт хамрагдаж чадахгүй болсондоо санаа зовж байв. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуус масктай учраас хоорондоо ярьж ойлголцож чадахгүй байх, мөн ЛГБТИК+ хүүхдүүдийн хувьд хомофобик гэр бүлийнхэнтэйгээ байнгын хамт байснаар хувийн аюулгүй байдалдаа санаа зовох, стресстэх зэрэг сэтгэл зүйн хувьд айдастай байснаа хэлж байв.

Коронавируст цар тахлын хөл хорионы үед боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосноос үүдэн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудалд онцгой анхаарах хэрэгцээ шаардлага тулгарсан юм. Засгийн Газрын зүгээс хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодлогын баримт бичиг цөөнгүй байгаа ч хөл хорио тогтоосон хугацаанд хүүхэд хамгааллын олон асуудал хөндөгдөж, хүүхдүүд хараа хяналтгүй болж, аюул эрсдэлд өртөж байсан нь харамсалтай.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ САНАЛ

Бид гамшиг, цар тахал, хямралын үед ч сурч боловсрох эрх хамгаалагдаж, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах нь энэ төрлийн болон бусад хямралд авах хариу арга хэмжээний хамгийн чухал стратеги байх ёстой гэж үзэж байна. Бид энэхүү хямралаас бүрэн гарч, эргэн сэргэхийн тулд эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн хамгааллын тогтолцоогоо бэхжүүлэх хэрэгтэй тул нийгмийн салбарын төсвийг хэвээр хадгалах, хамгаалах шийдвэр дээрээ хатуу зогсох шаардлагатай байна.

Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ нь хоорондоо холбоотой хүний суурь эрхүүд тул эдгээр салбарууд нийтийн өмч/баялаг хэвээр байх, тогтолцоог сайжруулах, хямралын үед үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх чадавхитай байхад анхаарахгүй бол нийгмийн эмзэг бүлгүүдэд хүрч чадахгүй байх эрсдэл харагдаж байна.

Цэцэрлэг, ЕБС болон бусад боловсрол сургалтын байгууллагууд нь зөвхөн сургалт, төлөвшлийн үйл ажиллагаа эрхлэх бус хүүхэд, гэр бүлийн хувьд хоол тэжээл, нийгэм-сэтгэл зүйн, эрүүл мэнд, аюулгүй байдлын, хүүхэд хамгааллын зэрэг олон талт үйлчилгээ үзүүлдэг газар болохыг энэ цар тахлын нөхцөл илрүүлэн гаргаж ирлээ.

Эмзэг болон маргинал бүлгүүдэд тохирох технологи болон технологийн бус арга хэрэгслийг үнэ төлбөргүй, хүртээмжтэйгээр ашиглан зайнаас сурах боломжийг олгож, хөдөө орон нутагт чиглэсэн сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, хамгийн эмзэг, гадуурхагдсан бүлгийнхэнд нөхцөл байдалдаа тохирсон чанартай боловсрол, сургалтанд хамрагдах боломжийг олгох чиглэлээр Засгийн Газраас илүү их хүчин чармайлт шаардаж байна.

Мөн халдварт өвчний эрсдэлгүй гэж үзсэн алслагдмал орон нутгийн зарим цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжтой байсан бөгөөд манай Засгийн газар үүнийг дүүрэн ашиглаж чадсангүй.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Цаашдаа янз бүрийн гэнэтийн осол, байгалийн гамшиг, өөр төрлийн халдварт өвчнүүд улс орныг хамарч аюулт байдал үүсэхэд төрийн тодорхой бодлого, түүнд зарцуулах төсөв, урьдчилан сэргийлэх аргачлал, заавар зөвлөгөө бэлэн байх

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд эмзэг, ядуу өрхийн хүүхдүүдэд боловсролыг хүртээмжтэй олгоход чиглэсэн заалт нэмж, төсөвт тусган үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Дээрх хуулинд хүний эрхийн иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог тусгайлан зааж хуульчлах

Онцгой байдлын үед салбарын яамнаас гарч байгаа шийдвэрүүд дээр тухайн арга хэмжээний хэрэгжилтэд шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэж зааж өгөх,

Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгад онц байдлын үед бүх шатны сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах талаар нэмэлт бүлэг оруулах, төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийн асуудлыг нарийвчлан зохицуулах

Салбарын төсөв санхүүгийн мэдээллийг Шилэн данснаас авах шаардлагыг Сангийн болон бусад салбарын яам тавьж байгаа ч тэнд тавигддагаас өөр төрлийн мэдээлэл шаардахад гаргаж өгөхгүй байгааг анхаарч, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд гарсан цоорхойг нөхөх арга хэмжээ авах,

Төрийн үйлчилгээний боловсрол, эрүүл мэнд зэрэг гол салбаруудын хөгжилд анхаарах, салбарыг сулруулахгүй байх, төсөв хөрөнгийг өөр салбарт шилжүүлж зарахгүй байх, богино хугацааны шийдлүүдээс гадна урт хугацааны алсын хараатай хандах

ТУСГАЙЛСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хөл хорионы үед авах түр зуурын арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхийн зэрэгцээ цахим болон зайны сургалтын талаарх бодлого, зохион байгуулалтыг урт хугацаанд харж төлөвлөх, үүнд дараах стратегиудийн чиглэлээр анхаарах:

- (1) холбоо харилцааны найдвартай дэд бүтэц,
- (2) сурагчдад ээлтэй сургалтын арга хэрэгслүүд,
- (3) сургалтын материал, тохирох дижитал эх үүсвэрүүд
- (4) үр дүнтэй багшлах, сурах арга зүй,
- (5) багш, сурагчдад үзүүлэх үйлчилгээ, үр ашигтай, дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэх, мэргэжил аргазүйн байгууллагуудыг дахин зохион байгуулах
- (6) Засгийн газар, хувийн хэвшил, сургуулиудын хамтын ажиллагааны хэлбэрүүдийг төлөвлөх

БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- Боловсролын салбарын хэмжээнд ашиглах цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх
- Зайны сургалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхдээ дараах зарчмуудыг баримтлах

- Хүүхдийн тасралтгүй өсөн, хөгжих хэрэгцээн дээр суурилж, хөгжлийн үйл ажиллагааг ямар ч үед (урт хугацаанд өвчтэй үед эмнэлгээс болон гэрээс гм) сурах үйлийн тасралтгүй байдлыг хангах
 - Багш, суралцагчдын ялгаатай байдлыг хүндэтгэх, түүнд нийцэхүйц үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх
 - Хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл үүсэхээс сэргийлэх,
 - Багш суралцагчдыг ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх
- Сургалтын хөтөлбөрийг нягтруулах, нэгтгэх, хичээлүүдийг интеграцчилах байдлаар эрчимжүүлсэн болон түргэвчилсэн байдлаар сурах боломжтой болгох
 - Багш нарын зайны/теле/цахим сургалт хичээлийг төлөвлөх, удирдах, зохион байгуулах арга зүйг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, багш цахим хичээл заах, сурагчидтайгаа цахимаар харилцах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх тогтмол сургалт зохион байгуулах
 - Теле/онлайн сургалтын үнэлгээний аргыг сайжруулах, аргачлалыг багш нарт сургах. Цахим/теле хичээл авсан тохиолдолд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам шинээр бий болгох, ингэхдээ суралцагчдын ялгаатай хэрэгцээг хүндэтгэж үзэх
 - Багш нарын онлайн сургалтын платформ ашиглахад шаардлагатай англи хэл, компьютерийн хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэх
 - Багшийг зайны сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, сургууль, төрөөс хангахад анхаарах, зайны сургалтад шаардлагатай багшид зориулсан гарын авлага, цахим материалын тоог нэмэх, мэдээллийг боломжит олон хувилбараар хүргэх, багшаас гарч буй нэмэлт зардлыг (тухайлбал, утас, интернетийн төлбөр, суралцагчдын гэрээр явахад зарцуулж буй унааны зардал) бууруулах талаар дэмжлэг үзүүлэх.
 - Дээд боловсрол болон мэргэжлийн боловсрол сургалтын түвшинд зайны сургалтыг чанартай явуулах, илүү боловсронгуй болгоход анхаарах, үүнд: (а) сургалтын материалыг бэлтгэхдээ маш бага хугацаанд их багтаамжтай мэдээллийг суралцагчдын анхаарлыг боломжит хамгийн их хэмжээгээр татахаар дэвшилтэт технологиуд болох AR/VR/MR технологиудыг үр дүнтэй ашиглаж бэлтгэх, (b) сургах-суралцах процесс нь багш-оюутны хамтын ажиллагаа оролцооны үр дүнд бий болдог учраас багш нараа цахимаар орчин үеийн дэвшилтэт технологийн бүхий л боломжуудыг ашиглан хичээл заах, сургах, оюутны суралцах үйл явцыг үр дүнтэй зохион байгуулах арга зүйд сургах, дадлагажуулах, (с) багш бүр өөрийн заадаг хичээлээр чанартай сургалтын материал хэрэглэгдэхүүн бэлтгэж, бэлтгэснээ бусад хүмүүст

ашиглах боломжтойгоор нээлттэй лицензтэйгээр ил болгох ингэснээр бие биеэсээ харилцан туршлага судалж суралцах, улмаар олон тооны чанартай сургалтын материалуудыг суралцагчдад хүртээмжтэй, нээлттэй болгох, (d) оюутнуудыг дижитал орчинд онлайнаар бие даан суралцах арга барилд сургах, тоглоомын аргууд, групп үүсгэн хэлэлцүүлэг хийх, багаар ажиллуулах, хүн бүрийн танин мэдэхүйн болон суралцах суурь чадварт тохирсон шатлан ахих, олон хувилбараар мэдлэг, чадвар, хандлагыг шалгах даалгаврууд бэлтгэж, сан үүсгэх

- Эцэг эх байх боловсрол, хүүхдээ хайрлах, анхааран хайхрах, тэдний хөгжлийг дэмжих, багштай хамтран ажиллах арга барилыг олгоход олон нийтийн телевизийг ашиглах, хүүхдийн бие даан суралцах арга барилыг дэмжих контенттэй болох зэргээр боловсролыг өргөн хүрээнд харж төлөвлөлтөө хийх
- Суралцагчдын гэрийн даалгаврыг онлайнаар хийж гүйцэтгэх, багш нартайгаа тасралтгүй холбоотой байх талаар эцэг эхчүүдийн ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх, мэдээлэл хийх, суралцагчийг компьютер, сургалтын хэрэгсэл, дата гэх мэт шаардлагатай зүйлсээр хангахад анхаарах
- Боловсролын салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг шинэ шатанд гаргах, БУМС-ийн ашиглалтыг сайжруулах
- Үндэсний ба аймгийн түвшинд зайны сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдлыг үнэлэх боловсролын бүх шат түвшингээр дүн шинжилгээний тайлан гаргах, хяналт үнэлгээ хийх, тухайлбал, цахим/теле сургалтын үед захирал, багш нарын ур чадвар, чадавх хэрхэн ахисныг үнэлж судлах, цаашдын хэрэгцээг тодорхойлох ажил хийх, мөрөөр нь зохих арга хэмжээг авах
- Онц байдлын үед ИНБ-ууд гол түншийн нэг гэдгийг батлан харуулах, эцэг эх, хүүхдүүдэд сэтгэл санааны, сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, Засгийн газартай мөр зэрэгцэн ажиллаж, шийдлүүдийг санал болгох, шийдвэр гаргахад оролцох боломж олгох
- Эцэг эх, гэр бүлийн гишүүд, суралцагч хүүхдүүд, багш нар, сургуулийн удирдлага, орон нутгийн удирдлага, шийдвэр гаргачид, хэвлэл мэдээлэл, ИНБ-ууд гэх мэт бүх талын оролцоо, идэвх, санаачилга, хариуцлагыг зангидах, дайчлах

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

- Нийгмийн ялгаатай бүлгүүд, ялангуяа эрсдэлт орчин нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх, чиглэсэн үйлчилгээг салбар дундын хамтын ажиллагаагаар хүргэх зайлшгүй шаардлага байгаа ба төсвийн зохицуулалт хийх
- Нийт гэр бүл, тэдгээрт амьдарч буй хүүхдүүд гэртээ байх хугацаанд эцэг

эхчүүдэд зориулсан хүүхэд хамгааллын зөвлөмжийг нас, хүйсийн ангиллаар нь улирлын нөхцөл байдалд тохируулан шинэчлэн гаргаж байх,

- Нийтийг хамарсан хөл хорио цээрийн үед шийдвэр гаргагчид, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үйлчилгээ бизнесийнхээ хүрээнд “Нэгдүгээрт хүүхэд” байх уриалгыг гаргаж, хүүхдийг аливаа эрсдлээс хамгаалахад бүх нийтийн анхаарлыг хандуулдаг байх,
- Хүүхдүүд тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, хүчирхийлэл үүний дотор бэлгийн хүчирхийллийн золиос болохоос урьдчилан сэргийлэх бодлого гаргах, болзошгүй эрсдлээс тэднийг ангижруулах орчин, нөхцөл, хамтын ажиллагаа, хүний нөөц, төсвийн бэлтгэлтэй байх
- Асрамжийн газар, 24 цагийн цэцэрлэг, хамгаалах байранд байгаа, хэвтрийн–гэрээр сурдаг зэрэг маш эмзэг бүлгийн суралцагчдын сурч боловсрох эрхийг хангахад анхаарах
- Утас болон онлайнгаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг эрчимжүүлэх.
- Олон нийтийн мэдээллийн эх үүсвэр ашиглан өрх гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцааг дэмжих, стресс бууруулах арга замуудыг сурталчлах, зэрэг хандлага нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах
- Ахуйн хүрээний архидалт (гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 91.8%, зөрчлийн 94.2% нь гэр, орон сууцад гарсан) -ыг бууруулахад согтууруулах ундаа борлуулах цэг, цагийн хуваарьт хязгаарлалт хийх, үнийг татвараар зохицуулах. Эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын зөв хэв маягийг таниулах, сурталчлах, зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах.

БОЛОВСРОЛЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Эрүүл мэнд, боловсролын салбарын давхацдаг асуудлуудад анхаарал хандуулах, сургуулийн ус ариун цэврийн байгууламж, сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах урт хугацааны шийдлүүдээ орхихгүй авч явах, төсвөө хэмнэж өөр салбарт шилжүүлэх биш салбарын тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхэд зарцуулах
- Онцгой байдлын үед төсвийн зохицуулалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Цахим сургалтын дэд бүтцийг бий болгох, чадавхийг нэмэгдүүлэх, холболтыг чанартай найдвартай болгох зэргээр боловсролын цахим шилжилтийг хийх төсвийг боловсролын салбарт хангалттай хуваарилах
- Боловсролын салбарын төсөвт гэнэтийн зардал гэсэн зүйл ангийг нэмж төсөвлөж байх
- Багшийн цалин хөлсөнд хэмнэлт хийж, багш дутагдах явдлыг гүнзгийрүүлэхгүй байх

- Сургуулиуд хэдийгээр интернэтэд холбогдсон ч гэсэн, зөвхөн мэдээлэл зүйн кабинэтээр хязгаарлахгүй багш нарын интернэт ашиглах боломжийг сургууль дээрээ бүрдүүлж өгөх, ялангуяа сургуулиудад харилцаа холбооны зардал хангалттай төсөвлөх
- Олон улсын хандив тусламж болон бусад төсвөөс гадуур орж ирж байгаа хандив, тусламж, хэмнэлтийн эд хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих боломж олгох, үр дүнтэй үйл ажиллагаанд зарцуулж байгаа гэдгээ ил тод ойлгомжтой байдлаар нийтэд мэдээлэх
- Боловсролын яамны Шилэн дансны хөтлөлтийг сайжруулах
- Шилэн дансанд “Ковид 19 цар тахалтай холбоотой мөнгөн ба материаллаг хандив тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ” хэмээх 2020 оны 7 дугаар сараас шинээр үүссэн цэсийг бүрэн дүүрэн хөтлөх
- Төсөв санхүүжилтийн ил тод байдлыг хангах талаарх үйл ажиллагааг яамны Авилгатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах

ТЭГШ ХАМРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- Онцгой байдлын үеийн боловсролыг цаашид анхаарч, бусад улс орны туршлагаас суралцаж, сургалтын олон хэлбэрээр боловсролын үйлчилгээг тасралтгүй байлгахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авч, салбарын удирдлага, багш нарыг сургах
- Яамны болон аймаг, нийслэлийн түвшинд тодорхой чиглэлээр, тухайлбал хичээл сургалтаас орхигдох магадлалтай суралцагчдын гэх мэт мэдээлэл-дата цуглуулах, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш нараас тулгамдаад байгаа асуудлын талаар яаралтай асуулга авах, хариу дэмжлэг үзүүлэх гэх мэт шуурхай үйл ажиллагааны горим нэвтрүүлэх
- Олон хүүхэдтэй айл эхний ээлжинд төгсөх анги эсвэл 1-р ангийн сурагчиддаа илүү хандаж теле хичээл үзэх боломжоор ханган, өөр бусад хүүхдийн боловсролын асуудал орхигдох зэрэг байдал үүсч байгааг теле хичээлийн хуваарь гаргахдаа анхаарах
- Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдүүд бие дааж судлах контент, текст, асуулт хариулттай, сонирхолтой, хүртээмжтэй контентүүд гаргах, зөвхөн багш заахаас гадна хүүхэд өөрөө тухайн хичээлийн агуулгаа бие даан өөрийн хурд нөхцөлд тааруулан судалдаг байх
- Хичээл тус бүрийн агуулгыг багтаасан хүүхэд бие даан судлах боломжтой Интерактив Програм гаргах, энэ нь ХБ-тэй хүүхдүүд ашиглаж болох хүртээмжтэй байх
- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох шалгуур нь тодорхой биш, мөн комисс тодорхойлдоггүй гэх мэт асуудлуудаас болоод маш олон хүүхэд

хоцрогдож, асуудлыг гадна үлдээд байгаад анхаарах

- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт маш муу байгаад анхаарах
- Цаашид зайны сургалтын чанар, гүйцэтгэлийг сайжруулахын тулд боловсролын салбараас бусад оролцогч талуудад хандсан тухайлбал, сургуулийн удирдлагууд, багш, ажилтнуудад төдийгүй эцэг эх, асран хамгаалагч, нутгийн иргэд, сурагч, оюутнууд, ИНБ-уудад хандсан, хамруулсан дэмжлэг, үйл ажиллагааг өргөн хүрээнд харж зохицуулалт хийх. Жишээлбэл, Эцэг эхийг үйлчилгээний чанарыг сайжруулахад татан оролцуулах, улмаар үйлчилгээг тасралтгүй засан сайжруулах тогтолцоо бий болгох
- Сургалтын үйл ажиллагааг зайн сургалтаар зохион байгуулахдаа алслагдсан сум, өрхийн хүүхдүүдэд гар утас, ТВ, радионы хэрэглээ, сүлжээний хүртээмжтэй байдал зэрэг зайн сургалт зохион байгуулах боломжийг судлах, сайжруулах
- Нийгмийн эмзэг бүлгийн өрхөд амьдарч байгаа хүүхдүүдийн зайн сургалт хүртэх боломж, хүртээмжийг урьдчилан судлах, алслагдсан сум, өрхийн хүүхдүүд, нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд цахим бус байдлаар сурах боломжоор хангах, тухайлбал, Суралцах багц бэлтгэн хэвлүүлж тараах, хурааж авах, шалгах гэх мэтээр
- Нийслэл, аймаг, дүүрэг, сум, баг, хороо гэх мэт орон нутгийн удирдах байгууллагаас эмзэг бүлгийн айлын хүүхдүүдийг онлайн хичээлээ хийхэд зориулж, онцгой байдал үүссэн энэ цаг үед интернет, компьютер техник хэрэгслээр хангасан (1-3 компьютертэй) халдвар хамгаалал бүхий өрөө гаргаж, цагийн хуваарийн дагуу үйлчлэх гм дэмжих бодлого баримтлах
- Цахим сургалтаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад эцэг эхийн боловсрол олгох, зайн сургалтын агуулгад нэмэлтээр бусад хичээлүүдтэй хавсарсан байдлаар хүний эрх, хүүхдийн эрх, эерэг хүмүүжлийн арга, хүүхэд хамгаалал, эрүүл мэндийн боловсролыг багтаах зайлшгүй хэрэгцээ гарч байгааг анхаарах
- Сургууль хаах үед өөрийн орны болон сурагчдын ялгаатай чадавхид нийцүүлсэн зайн сургалтын нэмэлт хичээл, хэвлэмэл материалууд: дасгал ажлын дэвтрүүд, бичмэл гэрийн даалгаврууд, сониноор өгөх даалгаврууд зэрэг хувилбарт шийдлүүдийг хайх, хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийг зарцуулах
- Эрүүл мэндийн боловсролоор дамжуулан суралцагч, эцэг эхчүүдийн КОВИД-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдүүлэх, гараа тогтмол угаах зэрэг эрүүл дадал хэвшил суулгах, цахим орчинд биеэ авч явах байдалд өөрчлөлт гаргах зэргээр сургалтын зорилго зорилтод тохируулга хийх
- Теле хичээлд хөгжимчин, тогооч, зурагчин зэрэг мэргэжлийн хүмүүсийг

оролцуулж, хичээлийг сонирхолтой, бодитой болгох, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй багш, үндэстний цөөнхийн багшаар заалгах зэрэг арга барилуудаа шинэчлэх

- Суралцагчдад онлайн сургалтад хамрагдах, бие даан суралцах арга барилыг эзэмшүүлэхэд анхаарах
- Хичээл эргэн ороход ядуу айлын хүүхдүүдэд халдвар, хамгааллын хэрэгсэл бүхий тусламжийн багц олгох: маск, гар ариутгагч, саван гэх мэтийг багтаасан Бага насны хүүхдүүдэд олон янзын эрүүл мэнд, сэтгэл зүйн өөрчлөлтүүд байдаг, эдгээрийг оюуны хомсдол гэж үзэх, тусгай сургууль руу шилжүүлэх явдал гарч байгаад анхаарлаа хандуулах, судалгаа хийх, тэгш хамруулан сургах талаар зөвлөмж чиглэл өгөх,
- Сумдын сургуульд 3-4 ангид сургалтаар хоцорч яваа хүүхдүүдийг илүү анхаарч үзэх, орон нутгийн багш нарт чиглэл удирдамж өгөх
- Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд амьдардаг үндэстний цөөнх болсон цаатан иргэд сумаасаа баруун тайга-55-60 км, зүүн тайга 30-35 км хол амьдарч байгаа тул теле/цахим хичээлд хамрагдахгүй байгаа ба сургуулийн зүгээс цаасан хэлбэрээр даалгавруудыг хүргэж байгаа хэдий ч урцанд хичээл хийх орчин нөхцөл төдийхэн бүрддэггүй (зай талбай бага, хүйтэн ... гэх мэт) тул хичээлийн хоцрогдолт үүсч байгаад анхаарах, тусгайлсан арга хэмжээ авах
- Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тува бага сургуулийн тува хүүхдүүдийн хувьд тус сургуулийн багш нар тува хэлний теле хичээл бэлтгэж, аймгийн төвийн Дербес, ТВ4 телевизэд бичүүлсэн боловч энэ 2 тв-ээр бүрэн гүйцэт гардаггүй зөвхөн кабелийн сувагтай айлд л гардаг тул эх хэл буюу тува хэлээр теле хичээл үзэх боломж хязгаарлагдмал байгааг анхаарах
- Танхимын болон бусад сургалтын боломжийг судлах, радио хүртээмжтэй байгаа хөдөө орон нутагт, тухайлбал, Баян-Өлгий аймгийн хувьд 9 цагийн радио нэвтрүүлэг эх хэл дээр явдаг болохоор малчин айл бүрт хүрэх боломжтой байгааг ашиглах
- Гэр сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, нэгдсэн хөтөлбөр, аргачлал бий болгож хууль зүйн орчныг сайн бүрдүүлэх нь сургалтын тэгш бус байдлыг арилгахад чухал үүрэгтэй гэж үзэж байна.

*

*

*

“Бүх нийт боловсролын төлөө!”

Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

- Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;
- Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;
- Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;
- Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;
- Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;
- Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;
- Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;
- Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;
- Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;
- Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

